# ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## (2016-2021 он)

**2016 он**

## АГУУЛГА


Товчилсон үг ......................................................................................................................3
Нэр томьёоны тайлбар..........................................................................................................4

Өмнөг үг...............................................................................................................................7

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА**

**Нэг. Өлзийт сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үндэслэл.................................8
1.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан эрхзүйн баримт бичгүүд ..............................................................................................8
1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим.....................................................................................................................7
1.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний онцлог, ач холбогдол............................7
1.5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтууд...............................8
1.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим.............8
1.7. Байгаль орчны менежементийн төлөвлөгөөний хамрах хүрээ........................................8

**Хоёр. Дундговь аймгийн Өлзийт сумын танилцуулга**

2.1. Сумын ерөнхий танилцуулга...................................................................................9
2.2. Сумын байгаль орчны салбарын алсын хараа, эрхэм зорилго .......................................9
2.3. Сумын байгалийн үнэт зүйлс...................................................................................9
2.4. Сумын хэмжээнд хэрэгжиж буй байгаль орчны холбогдох менежментийн төлөвлөгөөнүүд тэдгээртэй уялдуулах нь........................................................................................ ...9

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ӨЛЗИЙТ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

**Гурав. Өлзийт сумын байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн салбарууд тэдгээрийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, түүний менежементийн өнөөгийн байдал**

3.1. Газар зүйн байршил.................................................................................................11
3.2. Газрын гадарга, хөрс................................................................................................11
3.3. Уур амьсгал..............................................................................................................12
3.4. Усны нөөцийн ашиглалт...........................................................................................13
3.5. Биологийн олон янз байдал түүний амьдрах орчин.......................................................14
3.6. Тусгай хамгаалалттай газар нутаг..............................................................................14
3.7. Ашигт малтмал ашиглалт..........................................................................................15
3.8. Агаарын бохирдол, цэцэрлэгжилт ..............................................................................15
3.9. Хог хаягдал..............................................................................................................16
3.10. Соёлын өвийн хамгаалал..........................................................................................16
3.11. Эдийн засгийн салбар...............................................................................................17
3.11.1. МАА-н салбар........................................................................................................17
3.11.2. Уул уурхайн салбар.................................................................................................17
3.11.3. Аялал жуулчлалын салбар........................................................................................17

**Дөрөв. Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон эрсдэл түүний зэрэг, талууд хоорондын харилцааг тодорхойлсон үнэлгээ**

4.1. Сумын эдийн засгийн голлох салбарууд тэдгээрийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл түүний зэргийн матриц....18
4.2. Байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн салбарт оролцогч талууд, хоорондын зөрчил түүний зэргийн матриц ....21
4.3. Байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн салбарт оролцогч талуудын зөрчил түүний өмнө үүрэг хүлээгчдийн матриц.... ....24
4.4. Байгалийн нөөцийг ашиглагч талууд ба үнэт зүйлс хоорондын харилцааны матриц....25
4.5. Сумын байгаль орчны өнөөгийн төлөв байдалд хийсэн СВОТ дүн шинжилгээ....26

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОМТ –НИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ЗАМУУД**

**Тав. Байгаль орчны менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөө**

5.1. Газрын менежментийн төлөвлөгөө....28
5.2. Усны менежментийн төлөвлөгөө....30
5.3. Биологийн олон янз байдал түүний амьдрах орчны хамгааллын менежментийн төлөвлөгөө....31
5.4. Түүхийн дурсгал, соёлын өвийн хамгааллын менежментийн төлөвлөгөө....33
5.5. Бусад байгалийн нөөцийн болон хамгааллын менежментийн төлөвлөгөө
5.5.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө....34
5.5.2. Агаарын бохирдлыг бууруулах,ногоон байгууламжийг өргөтгөх менежментийн төлөвлөгөө....37

**Зургаа. СБОМТ-г хэрэгжүүлэх тогтолцоо**

6.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг хариуцлага....39
6.2. БОМТ-г хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг чадавхижуулах....39
6.3. Хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээ ба тайлагнал....39
6.4. Санхүүжилтийн тогтвортой, баталгаатай эх үүсвэр....40

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ**

7.1. Санхүүгийн тогтворгүй байдлаас үүсэх эрсдэл....40
7.2. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүсэх эрсдэл....41
7.3. Удирдлага зохион байгуулалт талуудын оролцооны чанараас хамаарах эрсдэл....41
7.4. Улс төрийн тогтворгүй байдал, төрийн залгамж чанар алдагдахаас үүсэх эрсдэл....41

Хавсралт материалууд

Ашигласан материал

БОМТ боловсруулахад оролцсон, санал өгсөн хүмүүс

## Товчилсон үг

| | |
|---|---|
| БОНХАЖЯ | Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яам |
| ГОУХАН | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг |
| ДЦГ | Дархан цаазат газар |
| | Байгалийн нөөц газар |
| | Дурсгалт газар |
| | Шувуудад чухал газар |
| ЗГ | Засгийн газар |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| НҮБХХ | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр |
| СБОМТ | Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| | Байгаль орчны хяналтын улсын байцаагч |
| | Төрийн бус байгууллага |
| | Бичил уурхай |
| | Мэргэжлийн хяналтын газар |

**Нэр томъёоны тайлбар**

| | |
|---|---|
| Байгаль орчинд нөлөөлөх байдал: | Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн болон хүний үйл ажиллагаа эрчимжиж хөгжихийн сацуу байгалийн нөөцийг ашиглах хэрэгцээ өсөн нэмэгдэж, тэр хийрээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, дарамтыг бий болгож байгааг нөлөөлөх байдал гэнэ. |
| Байгаль орчны удирдлагын тогтолцоо: | Байгууллагын байгаль орчны нөлөөллийг удирдах, хянах тогтолцоо болох ISO 14001 олон улсын стандарт |
| Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ: | Хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулахад төсөл, хөтөлбөр, бодлогыг хэр амжилттай хэрэгжүүлж байгааг харьцуулан тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үргэлжлэх үйл явц |
| Ногоон хөгжил: | Монголын өнөө болон хойч үеийнхний  сайн сайхан амьдрах баталгааг хангахын тулд эдийн засгийн хөгжлийг тогтвортой хангах нөөц буюу экосистемийн үр өгөөжийг үнэлж, урт хугацаанд тогтвортойгоор хадгалж хөгжихийг ногоон хөгжил гэнэ гэж томъёолж болох юм. |
| СВОТ: | Үйл ажиллагааг шинжлэхдээ *ДАВУУ* ба *СУЛ* тал, *БОЛОМЖ* ба *АЮУЛ ЗАНАЛ*-ыг нь илрүүлж гаргаж ирдэг арга юм. Энэ аргыг маш олон (хувь хүн, байгууллага, улс орон, үйл явдал г.м.) олон зүйл дээр ашиглаж болно. |
| Тогтвортой хөгжил: | Хорин нэгдүгээр зууны дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн хөгжлийн гол хандлага бөгөөд  тогтвортой хөгжил нь байгаль орчин - эдийн засгийн тэнцвэртэй харьцааг бүрдүүлэн, үүний үндсэн дээр иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг арилгах, байгалийн нөөц баялагийг боломжит хэмжээнд нь зохистойгоор ашиглах, орчны бохирдол, доройтлоос сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн хөгжих зарчмыг хэрэгжүүлэхийг тогтвортой хөгжил гэнэ. |
| Хөгжлийн үйл ажиллагаа: | Хөгжлийг хангах зорилгоор хийж буй түнш /хандивлагч ба хандивлагч бус/-ийн дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэл. Тайлбар: Жишээ нь бодлого, төсөл, хөтөлбөрийн зөвлөмж |
| Шалгуур үзүүлэлт: | Ахиц өөрчлөлтийг хэмжих, үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтийг тусгах эсвэл хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийн гүйцэтгэлийг үнэлэхэд дэмжлэг болох энгийн, найдвартай аргыг бий болгох тоон болон чанарын хүчин зүйл эсвэл хувьсах үзүүлэлт |
| Тусгай | Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон |

| | |
|---|---|
| хамгаалалттай газар нутаг | ургамал, амьтан бүхий газар, түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор улсын хамгаалалтад авсан газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутаг гэнэ.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангилна. Үүнд:<br>1. дархан цаазат газар /ДЦГ/<br>2. байгалийн цогцолборт газар /БЦГ/<br>3. байгалийн нөөц газар /БНГ/<br>4. дурсгалт газар /ДГ/ |
| Шувуудад чухал газар | Шувуудад Чухал Газар /ШЧГ/ гэдэг нь олон улсад мөрдөж байгаа тогтсон шалгуурын дагуу шувууд болон тэдгээрийн хамгаалалд үзүүлэх ач холбогдлоороо бүс нутаг, олон улсын хэмжээнд өндөр болох нь тогтоогдсон газрууд юм. Манай улсад 70 ШЧГ бий. |
| Рамсарын жагсаалтад бүртгэлтэй газар | Ус, чийг, намгархаг газар нутгийг биологийн олон янз байдлыг нийтэд нь хадгалан хамгаалах болон хүн төрөлхтний нийгмийн сайн сайхан оршин тогтнохуйд нэн чухал ач холбогдолтой экосистем бүхий олон улсын ач холбогдол бүхий газруудаа Рамсарын конвенцид нэгдсэн улс орнууд тусгай шалгуурын дагуу жагсаалтанд оруулж хамгаалдаг. Монгол улсаас Рамсарын жагсаалтад 6 газар бүртгэгдсэн. |

**Өмнөх үг**

Та бидний ажиллаж амьдарч байгаа өссөн төрсөн нутаг Өлзийт сумынхаа байгалийн нөөц, баялагийг зөв зохистой ашиглах, хамгаалах, иргэдэд ил тод хүртээмжтэй байлгах ирээдүйн төлөвлөлт хийж, иргэн бүрийн оролцоотой энэ нутгийнхаа эзэн нь болж хөгжүүлэхэд гол зорилго болгон тодорхойлсон юм.

Байгаль, цаг агаарын өөрчлөлт, ган зудын давтамж, цөлжилт, элсний нүүдэл, хариуцлагагүй уул уурхай нэмэгдэж байгаатай холбогдуулж ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, өрхийн нэмэлт орлого бий болгох, уул уурхайн олон талт зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Манай суманд хөгжих боломжтой салбарууд, тэдгээрт тулгамдаж буй бэрхшээлийг гарган, тэдгээрийг хөгжүүлэхэд давуу тал, сул талаа тодорхойлж хөгжлийн чиглэлтэй болж “Ногоон сум” болж ажиллаж, амьдрана гэдэг нь бидний маш том ололт юм.

Энэхүү ногоон ирээдүйрүү чиглэсэн “эко” гэж хэлж болох *байгаль орчны менежментийн цогц төлөвлөгөө* боловсруулах томоохон ажилд арга зүйн болон бусад дэмжлэг тусалцаа үзүүлж, гар бие оролцон хамтран ажилласан “Хил хязгааргүй алхам” ТББ-ын хамт олон, ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, ЗДТГ-ын холбогдох албан хаагчид, БЗД нар, байгаль хамгаалагч нартаа баярласан талархсанаа илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилтыг хүсье.

Бид энэ өргөн уудам газар нутгийнхаа эзэн нь байж хамтаараа хөгжүүлнэ гэдэгт илтгэлтэй байна.

ИТХ-ын дарга

Х.ОТГОНМӨНХ

ЗАСАГ ДАРГА

И.ЭРДЭНЭБИЛЭГ

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

## НЭГ. ӨЛЗИЙТ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1.1. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үндэслэл

Манай улсад сүүлийн жилүүдэд байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, ашиглагч нь хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг эргэн сэргээх, байгалийн эвдрэл хохирлыг үнэлэх, унаган төрхөд дөхүүлж сэргээн ашиглагч нь төлөх хандлага үзэл санаа бүхий байгаль орчны чиглэлийн 30 гаруй хууль, маш олон тооны дүрэм, журам, үндэсний хөтөлбөр, стандартууд гарч мөрдөгдөж байна. Эдгээр хөтөлбөр, бодлогуудад үндэслэн аймгаас дэд хөтөлбөр төлөвлөгөө гарч, тэдгээрийг сумын түвшинд хэрэгжүүлэх зохицуулалттай. Эдгээр шатны бодлогууд өөр өөр салбаруудаас тус тусын чиглэлээр гарснаар сумын түвшинд хэрэгжүүлэхэд ажил үүргийн давхцал, салбар хоорондын уялдааг тодорхой тусгаж өгөөгүй, төлөвлөгөөнд санхүүгийн эх үүсвэргүй тул хэрэгжүүлэх боломжгүй арга хэмжээнүүдийг тусгадаг зэрэг нь сумын түвшинд бодлого хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болдог.

“Өлзийт сумын 2009-2021 оны нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулахад “*Уул уурхайг түшиглэх үү?, эсвэл мал аж ахуйг түшиглэх үү?*” гэсэн хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлох иргэдээс авсан санал асуулгаар *мал аж ахуйг түшиглэнэ* гэсэн санал давамгайлсан, мөн сумын Засаг даргын санаачилснаар “Ногоон сум” болох зорилгыг ИТХ-аар дэмжин баталгаажуулж тодорхойлсон.

Иймээс Өлзийт сумынхан бид сумынхаа байгалийн нөөц, баялагийн ашиглалт, хамгаалалтыг алсын хараатай зохицуулах, тогтвортой хөгжлийг хангах, байгаль дэлхийн унаган төрхийг аль болох эвдрэл хорогдол багатай ашиглаж, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилго бүхий сумын байгаль орчны бүхий л асуудлыг нэгтгэсэн, ойрын ирээдүйг харсан цогц, менежментийн төлөвлөгөөг хийх шаардлагатай болсон юм. Энэ төлөвлөгөөг бид “СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ДУНД ХУГАЦААНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ” (СБОМТ) гэж нэрлэж байна.

Энэхүү СБОМТ-нд сумын газар ашиглалт болон байгалийн бүх төрлийн нөөц баялагийн ашиглалт, биологийн төрөл зүйлийн амьдрах орчин, байгаль орчныг хамгаалах асуудал, иргэдийн экологийн боловсрол, мэдлэг, оролцоо зэрэг олон талыг харгалзан тусгасан.

Төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээр сумын байгаль орчны нөөц баялгийн цогц суурь судалгаануудад үндэслэн байгаль орчныг хамгаалах, экологийн хүчин зүйлүүдийг тодорхойлох, байгаль орчныг нөхөн сэргээхэд ихээхэн ахиц гарч, сумын тогтвортой хөгжлийн алсын хараа, хэтийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх гол хүчин зүйлийн нэг болно.

### 1.2. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан эрх зүйн баримт бичгүүд

- Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/
- МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Байгаль орчны багц хуулиуд
- МУ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030 баримт бичиг /2016/
- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2016/

Холбогдох бусад хууль тогтоомжууд г.м голлох эрх зүйн баримтуудыг дурьдахаас гадна орон нутгийн засаг захиргаанаас гаргасан хүчин төгөлдөр зохицуулалтын баримт бичгүүд, түүнчлэн байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан болно.

### 1.3. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим

Сумын БОМТ-г боловсруулахад дараах зарчмыг баримталж ажиллалаа. Үүнд:

- БОМТ нь ЗГ-аас 2009 оноос хойш гарсан салбарын бодлого, хөтөлбөрийг сумын түвшинд хэрэгжүүлэх зорилтуудыг хангах, Сумын 2009-2030 оны хөгжлийн стратеги төлөвлөгөөтөй уялдсан, түүний хэрэгжилтэд дэмжлэг болох, уг баримт бичигт тусгагдаагүй байгаль орчны зорилтуудыг аль болох тусгаж уялдуулах;
- БОМТ – г боловсруулахад боломжит хэмжээнд олон талуудын оролцоог хангахыг хичээсэн бөгөөд ингэснээр байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй талуудын үүрэг, хариуцлага тодорхой болж оролцоо нэмэгдэх, ашиглагч нь хамгаалах замаар хариуцлагажих нөхцлийг бүрдүүлэх;
- БОМТ-нд байгаль орчны бүхий л бүрэлдэхүүн хэсгүүд: газар болон хөрсний асуудал, уур амьсгалын өөрчлөлт- ногоон байгууламж- агаарын бохидол, усны болон биологийн төрөл зүйл, түүний амьдрах орчин, түүх соёлын өвийн хамгаалал зэрэг өргөн хүрээнд эдийн засгийн салбар бүрээр өнөөгийн төлөв байдлыг үнэлж, сөрөг нөлөөллийн зэргийг бодитой үнэлэх;
- Оролцогч талууд болох төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн иргэдийн санал, дүгнэлтэд үндэслэх, эрхэм зорилго, итгал үнэмшил, хүсэл эрмэлзэлд нийцүүлэх;
- Ирээдүйгээ харсан, дунд хугацааны 5 жилийн зорилго, зорилтыг шийдвэрлэхээр төлөвлөсөн байх;
- Цаг үеийн тухайн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох боломжтой уян хатан байх;

### 1.4. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний онцлог, ач холбогдол

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгалийн нөөцийг ашиглагч бүхий л талууд болох малчин, бичил уурхайчид, уул уурхайн компани, аялал жуулчлал эрхлэгчид, төсвийн байгууллагын ажилчид, олон нийтийн байгууллагын төлөөлөл зэрэг бүхий л талуудын оролцоотой боловсрогдож, сумын тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлсон баримт бичгүүдийн нэг болсноороо онцлог юм. Нөгөө талаас олон оролцогч талуудын оролцоотой боловсруулж буй сумын байгаль орчны анхны гэж хэлж болохуйц хөгжлийн бодлогын баримт бичиг болж байна.

Энэхүү БОМТ нь байгалийн нөөцийг ашиглагч талууд хоорондын харилцаа, тэдгээрийн БО өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, сумын эдийн засгийн үйл ажиллагаануудаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллүүдийг эрсдэлтэй нь үнэлэн тогтоож үе шаттай хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлсон. Мөн сумын түүх соёлын ач холбогдол бүхий газруудыг тодорхойлж хамгаалалтыг бий болгох замаар эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг тодорхойлох, БО салбарын олон төлөвлөгөөг нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлэх, холбогдох албан тушаалтнуудын байгаль орчны талаар авч хэрэгжүүлэх гол үүрэг хариуцлагыг тодорхой болгосон, цаашид аливаа төслийн байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд суурь үндэслэл болох зэрэг онцгой ач холбогдолтой баримт бичиг болж байна.

### 1.5. Өлзийт сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

**Зорилго:**

Байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалт, хамгаалалтыг хангахад байгаль орчны гол оролцогч талуудын[1] оролцоо, үүрэг, хариуцлагыг тодорхойлж хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлэх, тайлагнах замаар тус төлөвлөгөөний алсын хараа, эрхэм зорилгод хүргэхэд оршино.

**Зорилтууд:**

Сумын БОМТ-ний зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- Байгаль орчны төлөв байдлын нарийвчилсан судалгааг дэс дараатай шинэчлэн гаргаж, түүнд тулгуурлан учирч болох сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж, хариу арга хэмжээ авах
- Байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад зарцуулна.
- Хүрээлэн буй орчны эрүүл аюулгүй байдлыг хангахад талуудын оролцоог нэмэгдүүлэх, чадавхижуулах
- МУ-ын ЗГ-ын байгаль орчны хөтөлбөр, төлөвлөгөөг орон нутагт үр дүнтэй хэрэгжихэд дэмжлэг үзүүлэх явдал

### 1.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- Улс төрийн нөлөөллөөс ангид, зөвхөн орон нутгийн тогтвортой хөгжил, иргэдийн нийтлэг эрх ашигт нийцүүлэн, жил бүр санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулж, талуудын оролцоотой хэрэгжүүлдэг байх;
- Сумын байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгуур баримт бичгүүдийн нэг гэж хүлээн зөвшөөрч жил бүрийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг тогтвортой хангах;
- Цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгох замаар сайжруулах, бусад бодлого төлөвлөгөөтэй нийцүүлэн сайжруулах, үнэлгээ хяналтыг талуудын оролцоотой тогтмол хугацаанд үнэлж байх;

### 1.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү төлөвлөгөө нь сумын эдийн засгийн голлох салбаруудаас байгаль орчинд хэрхэн нөлөөлж буйг, мөн байгалийн нөөцийг ашиглагч талуудын ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлж үнэлэх, тухай бүрт нь бууруулах, зайлсхийх, арилгах хариу арга хэмжээ авч байх зорилгоор боловсруулагдсан болно. Энэхүү баримт бичиг нь сумын эдийн засгийн дараах салбар, үйл ажиллагаануудад хамаарна. Цаашид эдийн салбар төрөлжиж нэмэгдсэн тохиолдолд тухай бүрт хамруулан авч үзнэ. Үүнд:

- Мал аж ахуй
- Уул уурхайн лиценз эзэмшигчид

[1]- Байгалийн нөөцийг ашиглагч талуудыг ойлгоно.

- Бичил уурхай
- Барилга, дэд бүтцийн үйлдвэр
- Аялал жуулчлал
- Ногоон байгууламж – дүйцүүлэн хамгаалах газар нутаг
- Хог хаягдлын менежмент
- Бусад

## ХОЁР. ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ТАНИЛЦУУЛГА




**2.1. Сумын ерөнхий танилцуулга:** Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу нь 1924 онд явагдсан засаг захиргааны зохион байгуулалтаар аймаг хошуудын нэрийг сольж Богдхан аймгийн Дэлгэрхангай уулын хошууны Өлзийт сум болгон өөрчилж Өвөр Дэрсэнэ ус хэмээх газар Сүрэнхор занги хэмээх даргатайгаар байгуулсанаас хойш ган гачиг, цагийн нөхцөл байдлаас шалтгаалан 30 орчим удаа нүүдэл хийж, 1965 оноос одоогийн Рашаант хэмээх уул устай газрыг түшиглэж төвлөрөн хөгжиж байна. Өлзийт сум нийслэл Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 380 км, аймгийнхаа төвөөс урд зүгт 100 км-т байрладаг. Говийнхоны хэлдгээр “тэмээний нуруун дээр явсан” тус сумын түүх ингэж эхэлсэн билээ. 1961 онд Өлзийт, Буянт-Овоо сумд, тэдгээрийн 6 нэгдлийг нэгтгэж Өлзийт сум, “Хоёрдугаар таван жил” нэгдэл хэмээн нэрлэсэн түүхтэй.

Одоогоор засаг захиргааны 6 багтай ба үүнээс хөдөөд 5 баг харьяалагддаг, сумын ИТХ, Засаг дарга, түүний Тамгын газар, 9 жилийн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв зэрэг төсөвт байгууллагууд ажиллаж, хувийн мал эмнэлэг 3, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг дэлгүүр, хоршоо, компани зэрэг ААН байгууллагууд ажиллаж байна.

**2.2. Алсын хараа:** Байгалийн нөөцийн зохистой, харицлагатай хэрэглээг цогцлоосон, экологийн тэнцвэрт байдлыг хангасан, тогтвортой хөгжил бүхий загвар “**Эко Өлзийт сум**” болох.

**2.3. Сумын байгалийн нөөцийн үнэт зүйлс** : Өлзийт сумaнд байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар, үлгэр, домог, кино зэрэг оюуны бүтээлүүд маш олон бий. Эдгээрээс Цагаан суварга, Өөш манханы элс, Хэвтээ босоо, Алаг зандангийн агүйнууд, Морин толгойн цав, Монтойн хайлааст ам зэрэг байгалийн өвөрмөц тогтоцтой үзэсгэлэнт газраас гадна, булаг билүүний хадны зургийн байгалийн галерей, хүний гараар бүтээгдсэн томоохон 8 сүм хийдтэй.[2]

### 2.4. Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний байгаль орчны хөтөлбөр, төлөвлөгөөнүүдтэй уялдуулсан нь

Засгийн газраас батлагдсан нийт 30 шахам байгаль орчны хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийн хэрэгжилт Өлзийт сумын түвшинд хэр хэрэгжиж байгааг үнэлж, БОМТ-нд тэдгээр төлөвлөгөөний орхигдсон болон давхардсан хэсгийг судалж нэгтгэн тусгалаа. Өлзийт сумaнд байгаль орчны салбарын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар албан ёсны төлөвлөгөө боловсруулж, зохих шийдвэр гаргаж

[2] - “Өлзийтийн хөгжил 2009-2020” хөгжлийн төлөвлөгөө. 17-р тал. 2009 он.

албажуулсан зүйлгүй ч жил бүр арга хэмжээ авч хэрэгжүүлэн тайланг төрийн холбогдох байгууллагуудад хүргэж ирсэн байна. Тухайлбал,

1. Монгол Улсын УИХ-ын 1998 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд сумын нийт газар нутгийн 60 хувийг буюу Ханын хэц, Цагаан суварга, Дэлийн хад орчмын 279021,46 га, Загийн ус орчмын 507997,69 га, Бан цохио орчмын 2687,09 га, Ханангийн хяр, Хатуу уул, орчмын 47554,43 га газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч Ашигт малтмалын газрын Кадастрын бүртгэлд бүртгүүлээд байна[3].
2. Засгийн газрын 1999 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Ус үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд сумын хэмжээнд өнгөрсөн онуудад 15 гүний худаг болон булаг шандыг хамгаалалтад авах арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.
3. Засгийн газрын 1999 оны 50 дугаар тогтоолоор "Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2015 онд сумын хэмжээнд хог хаягдлын төлбөрийн хэмжээг нэг өрх айлаас 2000 төг, ААН-ээс 10000 төгрөг байхаар сумын ИТХ-аас холбогдох шийдвэр гаргаж мөрдөж ажиллаж байна.
4. Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоолоор "Ойн тухай үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд сумын Загийн ус орчмын 507997,69 га газрыг Байгалийн нөөц газарт авч хамгаалсан байна.
5. Засгийн газрын 2003 оны 141 дүгээр тогтоолоор "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Цагаан суварга жуулчны баазад 10 га газарт Алтан харганы үр суулгасан нь одоогийн байдлаар ургалтын байдал 50 хувьтай байна.
6. Засгийн газрын 2002 оны 269 дүгээр тогтоолоор "Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Уул алтаргана, Хөтөл, Дэл хөнжил, Хэцүү тээг, Цант уул газруудад тархан суурьшсан байдаг. Өнгөрсөн онд Аргаль, Хамгаалах талаар орон нутгаас биотехникийн үйл ажиллагаа явуулсан нь амжилттай арга хэмжээ болжээ.
7. "Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2015, 2016 онуудад Ерөнхийлөгчийн зарлигаар БОАЖЯ-ны Сайдын тушаалаар "Нэг сая мод ургуулах хөдөлгөөн" улс даяар өрнөсөнтэй холбогдуулан сумын нийт нутгийн 4,1 га талбайд 2796 модыг суулгасан.
8. Засгийн газрын 1997 оны 255 дугаар тогтоолоор "Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 15 хүүхдийн бүрэлдэхүүнтэй Дундговь аймгийн Их газрын чулууны байгалийн цогцолборт газартай хамтран эко клуб байгуулан ажиллаж байна.
9. Ард иргэдийн дунд Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэг мэдээлэл олгох сургалтыг сүүлийн жилүүдэд төрийн болон, догорууд, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд орон нутгийн захиргаа, холбогдох мэргэжилтэнүүд иргэдэд экологийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна.
10. Эдгээрээс гадна Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, Бичил уурхайн газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө зэрэг баримт бичгүүд боловсрогдох суурь судалгаа хийгдэж байна.
11. Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Өлзийт сумын Дэл уулын хамар ус, Гучин хоёрт хэмээх газарт орших хадны зураг, Буган чулуун хөшөө цогцолбор дурсгал, Дэл уулын баруун Билүүт ууланд орших хадны зураг, Руни бичээс зэргийг улсын хамгаалалтад авсан байна.

[3] - 2015 онд ИТХ-ын АМГ-т илгээсэн албан тоот эсвэл АМГ-ын албан ёсны албан мэдэгдлийн дугаар

***Дүгнэлт:***

- ✓ Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Засгийн газрын үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрүүдтэй нягт уялдаж хийгдсэн бөгөөд зарим нэг орхигдсон буюу уялдаагүй төлөвлөгдсөн байгаль орчны асуудлыг энэ баримт бичигт тусгасан болно. Тухайлбал, Агаарын бохирдол, ахуйн хог хаягдал, сумын ногоон байгууламж, иргэдийн экологийн боловсролын зэрэг шинэ асуудал энд тусгалаа олсон болно.
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байгаа нь төрөөс гаргасан бодлого шийдвэр, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг, төлөвлөлт нь болно гэж үзэж байна.
- ✓ Энэхүү БОМТ нэгдсэн байдлаар гарсан нь салбар хоорондын байгаль орчны өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг нэгтгэн тодорхойлж байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ӨЛЗИЙТ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

### ГУРАВ. ӨЛЗИЙТ СУМЫН БАЙГАЛИЙН НӨӨЦӨД ТҮШИГЛЭСЭН ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

| | |
|---|---|
| Сумын байгаль орчны төлөв байдлын тухай товч танилцуулга | **3.1. Газар зүйн байршил:**<br><br>Сумын нутаг дэвсгэр нь физик газарзүйн мужлалаар говийн их мужийн Умард говийн гүвээт талын А тойрогт багтах ба хойд талаараа өөрийн аймгийн Хулд, Луус, Сайнцагаан сумдтай, зүүн талаараа Гурвансайхан, Өндөршил, Дорноговь аймгийн Мандах сумдтай, урд талаараа Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Цогт-Овоо зэрэг 3 аймгийн 9 сумтай хил залган оршдог. Зүүнээсээ баруун хил хүртлээ 220 км, хойноосоо урд хил хүртлээ 160 км урт сунаж тогтсон 1’542’114 га газар нутагтай, энэ нь аймгийнхаа нийт нутаг дэвсгэрийн 1/5-тэй тэнцэх хэмжээний өргөн уудам нутаг юм. Сумын төв буюу Рашаант нь Дундговь аймгаас урагш 100 км, Улаанбаатар хотоос 370 км-т байрладаг.<br>**3.2. Газрын гадарга, хөрс**<br>Сумын нийт нутаг дэвсгэрийн 87 хувийг нам уул, цав толгод, ухаа гүвээ, тэдгээрийн хоорондох тал хөндий хоолой бүхий газрууд эзэлдэг. Судалгаагаар элсэн манхан буюу нүүдэг нүцгэн элс 4,3 мянган га талбайг эзэлдэг нь тогтоогдсон. Элсэн манхан нь гадаргадаа салхины нөлөөллөөс хамгаалах ургамалгүй учир элсний нүүдэл ихсэж, цөлжилт явагдаж, бэлчээр, уст цэгийг дарж үгүй хийх явдал их байдаг. Хөрс нь Говийн их мужийн бор хөрсний бүсийн хойт, говийн мужийн Дундговийн харьяанд хамрагдана. Хөрсний бүтцэд уулын хөрс 24,5%, тал хөндийн хөрс 71,7%, бүс дундын хөрс 4,4%-ийг тус тус эзэлдэг.Сумын газар нутгийн хэмжээ 1 542 114 га, үүнээс хөдөө аж ахуйн эдэлбэр газар 1 290 515 га, ойн сан бүхий газар 58544 га, усны эдэлбэр газар 268 га, замын сүлжээний газар 3007,9 га, хот суурингийн эдэлбэр газар 313 га талбайг тус тус эзэлдэг.<br><br>Газар ашиглалт, газрын нэгдмэл сангийн мэдээлэл /2015 оны байдлаар/ |

Хүснэгт 1

| Нийт газар нутгийн хэмжээ 1542114 га | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөдөө аж ахуйн газар /га/ | | Хот тосгон бусад суурин газар /га/ | | | | Зам шугам сүлжээ /га/ | | Усны сан /га/ | | Ойн сан бүхий /га/ | Улсын тусгай хэрэгцээний газар /га/ | |
| 1290515.1 | | 313 | | | | 3007,9 | | 268 | | 58544 | 189466.5 | |
| Үүнээс: | | Үүнээс: | | | | Үүнээс: | | Үүнээс: | | Үүнээс: | Үүнээс: | |
| Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар | Бэлчээрийн газар | Барилга байгууламжийн дэвсгэр газар | Нийтийн эдэлбэрийн газар | Уурхайн дэвсгэр газар | Гэр хорооллын газар | Авто замын газар | Шугам сүлжээний газар | Нуур цөөрөм тойрмын эзлэх газар | Гол горхи, булаг, шандны эзлэх газар | Ой модоор бүрхэгдсэн газар /түүний дотор загаар/ | Ой тэлэн ургах нөөц газар | Байгалийн нөөц газар |
| 232,5 | 1290282,6 | 23,85 | 143,06 | 131,5 | 14,59 | 2984 | 23,9 | 259,8 | 8,2 | 51264 | 7280 | 189466,5 |

### 3.3. Уур амьсгал

Дундговь аймгийн олон жилийн дунджаар агаарын температур 1,1-4,7 градусын хооронд хэлбэлздэг байна. Хамгийн хүйтэн 1-р сард агаарын дундаж температур -16,7-19,6 градус, хамгийн дулаан 7-р сард агаарын температур 19,9-22,3 градус байна. Дундговь аймгийн агаарын дундаж температур 2,6 градусаар дулаарсан. Хамгийн дулаан 10 жил нь1982, 1995, 1997, 1998, 1999, 2001, 2004, 2006, 2007, 2008 онууд байлаа.Дулааны улиралд агаарын температур өсч байгаа нь харагдаж байна. 1981-1998 онд 17,7-20,2 градусын хооронд байсан бол 1999-2011 оны хооронд 18,7-21,8 градус болж өссөөр байна. Нутгийн өмнөд хэсгээр 2,6-3,7 градус, нутгийн хойд хэсгээр 2,0-2,1 градусаар дулаарсан. Нутгийн хамгийн өмнө хэсэгт орших Өлзийт суманд хамгийн дулаан буюу 3,7 градус харин Хойд болон баруун хойд талд байрлах Эрдэнэдалай өртөөн дээр хамгийн бага дулааралт буюу 2,0 градус ажиглагдсан байна.

Дундговь аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд хэт их халалт нэлээдгүй ажиглагдах болсон. 1981-1995 он буюу эхний 15 жилд 365 удаа тохиолдсон бол 1996-2011 он буюу сүүлийн 15 жилд 507 удаа болж даруй 145 өдрөөр дулаарсан байна. Харин хэт хүйтрэлт эхний 15 жилд 442 өдөр байсан бол сүүлийн 15 жилд 404 болж 38 өдрөөр буурсан байна. Энэ нь хуурайшилт ихсэж цөлжилтийг нэмэгдүүлж байна.

Дундговь аймгийн хэмжээнд жилдээ 23,8-66,7 мм хур тунадас ордог байна.

Дундговь аймгийн жилийн нийлбэр хур тунадасны явц буурсан хандлага ажиглагдаж байна. Зургаас харахад хур тунадасны өөрчлөлт агаарын температурыг бодвол сул хамааралтай байна. Сүүлийн 31 жилд Мандалговь өртөөнд 76,3-239,9мм, Сайхан-Овоод 60,0-215,7 мм, Эрдэнэдалайд 26,9-209,4 мм, Өлзийтөд 61,8-181,5 мм хооронд хэлбэлзэж байсан байна.

### 3.4. Усны нөөцийн ашиглалт

Өлзийт сумын усны нөөц газар нь Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаанд харьяалагддаг. Тус сав газрын захиргаанаас сумын усны нөөцийн талаар 2016 онд гаргасан дэлгэрэнгүй мэдээллийг авч үзлээ.



919,5 га талбай бүхий усны эдэлбэр газартай. Улирлын шинжтэй, задгай 11 булагтай. Сумын төвд төвлөрсөн усан хангамжийн цэвэр усны 2 эх үүсвэр, усан сан, ундны ус цэвэршүүлэх төхөөрөмж, ус түгээх 2 байртай. Сумын төвийн төсвийн байгууллагууд болон төвийн орон сууцны оршин суугчид цэвэр, бохир усны болон халаалтын нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон.

Хүснэгт 2

| Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд буй усны мэдээлэл | Худаг | | | | | Ажилтай | Ажилгүй | Даргадсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Өрөмдмө | цооног | Уурхайн худаг | Энгийн худаг | **Нийт** | | | |
| | 38 | 3 | 3 | 237 | **281** | 271 | 10 | |
| Булгийн нэр | | Булаг | | | | | | |
| | | Солбилцол | | | | | | |
| | | **эзэмшил** | **градус** | **мин** | **сек** | **градус** | **мин** | **Сек** |
| 1. | Энхийн булаг | Малчид | 45 | 12 | 10 | 106 | 47 | 51.5 |
| 2. | Хар толгойн булаг | Малчид | 45 | 13 | 1.5 | 106 | 53 | 14.2 |
| 3. | Солгойн булаг | Малчид | 45 | 11 | 7.8 | 106 | 47 | 50 |
| 4. | Зүүн булаг | Малчид | 45 | 10 | 44.6 | 106 | 15 | 38.5 |
| 5. | Баруун билүүн | Малчид | 44 | 26 | 11.3 | 105 | 51 | 57.2 |
| 6. | Шургуул булаг | Малчид | 44 | 33 | 13.9 | 105 | 50 | 10.4 |
| 7. | Хөөврийн булаг | малчид | 44 | 38 | 34,4 | 107 | 0 | 37 |
| 8 | Рашаант булаг | Малчид | 44 | 56 | 20.8 | 106 | 18 | 59.6 |
| 9. | Сүүжийн булаг | Малчид | 44 | 19 | 16.9 | 106 | 1 | 38.7 |
| 10 | Хармагтай | Малчид | 44 | 11 | 43.6 | 106 | 12 | 43.6 |
| 11 | Хөөвөр | малчид | 44 | 19 | 2 | 105 | 55 | 57.6 |

### 3.5. Биологийн олон янз байдал түүний амьдрах орчин




Намхан гүвээ толгод, хээр тал хосолсон нутгийн хойд талаар бут, харгана, таана, хялгана, хазаар өвс, голлон ургадаг бол элсэрхэг хөрстэй хоолой хөндий, тойром, цав сархиаг, хадан уул элбэгтэй өмнөд талаар хайлаас мод, заг, улаан бударгана, бор бударгана, багалуур, сондуул, шар мод, хотир, загсагал, шаваг мэт ургамал, хүнсний болон эмийн төрөлд хамрагдах гоёо, цулхир, зээрийн ундаа, чихэр өвс, хармаг, тэмээн хөх, хөмүүл зэрэг олон төрлийн ургамал ургана.

Амьтны аймгийн хувьд говийн энэ шаргал хөрсөнд идээшсэн аргаль, янгир, хар сүүлт, үнэг, хярс, цагаан зээр, чоно зэрэг ан амьтад нутаглана. Мөн тас, бүргэд, харцага, ногтруу, ууль, шар шувуу зэрэг хээр талын жигүүртэн шувууд нэн олон.

Загийн ус нь заган ойн ихээхэн нөөц бүхий үзэсгэлэнт газар бөгөөд шавранцар бор хөрсөнд нь баглуурт таана, хялганат, чулуусаг алаг өвс, баглуур хялганат, бор бударганат хялганат зонхилно. Загийн усны байгалийн цогцолбор газарт хар сүүлт бусад газраас арай илүү тоо толгойтой байдаг. Цагаан зээр, хярс, мануул, чоно, үнэг, өмхий хүрэн, шувуудаас ногтруу, хахилаг элбэг бий.

### 3.6. Тусгай хамгаалалттай газар нутаг

***Загийн усны БНГ***




Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн нутгийн заагаар орших заган ой бүхий говь нутаг. Энэ нутгийг 1996 онд УИХ-ын 43 дугаар тогтоолоор улсын хамгаалалтанд авсан ба Загийн усны байгалийн нөөц газар нь заган ойн тархалтын хамгийн залуу нөхөн ургалттай газар учраас тэдгээр загийг хамгаалах, нөхөн ургах нөхцлийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах зорилгоор байгалийн нөөц газар болгожээ. Нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг нам уулс, цав толгодын дунд хангай байдалтай орших талархаг газар эзлэх боловч дунд нь хунгар довцог элснүүд бий. Хамгийн том нь Хавтгай, Жаргалант уулын зүүн хойно орших **Өөшийн элс** юм. Булаг шанд байхгүй бөгөөд 10 гаруй гар худаг, уурхайн худагтай боловч зарим нь дарагдаж эвдэрсэн байна. Гадаргын ус ховор тул хүн мал суурьших нь цөөн, зэлүүд нутаг юм.

2015 онд Орон нутгийн тусгай хамгаалалтанд 6 байршилд нийт 919271,67 га газрыг авч АМГ-ын Кадастрын бүртгэлд бүртгүүлсэн нь сумын нутаг дэвсгэрийн 59.6 хувийг эзэлж

байгаа ба Загийн усны БНГ-ын талбай, Их газрын чулууны УТХГ-ын суманд хамрагдах хэсэгтэй нийлээд сумын нийт нутаг дэвсгэрийн 72,3 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна[4].

### 3.7. Ашигт малтмал ашиглалт

Тус сумын нутаг дэвсгэрт уран, зэс, нүүрс, нефть, алт, хайлуур жонш, шохойн чулууны илэрц ордуудтай. Буянтаас эхлээд Төхөмийн хоолой, Мөнхрөх, Аяга шанагын хоолой, Цагаан суварга хүртэлх талбайд уран, зэс, нүүрсний, Төхөм хавьд нефтийн, Дэл хөнжлийн хэцэд алт, Хөтөл уснаас цант, Цагаан ус хүртэлх газарт хайлуур жоншны, Замын сүүжийн ард шохойн чулууны орд, улаан, ногоон, шар, хүрэн гэх мэт зос хаа сайгүй тааралдана[5]. Одоогоор сумын бичил уурхай эрхлэгч иргэдийн 6 нөхөрлөл Шарангад гэдэг газарт албан ёсоор жонш олборлож байна.

2016 оны 05 сарын 10 ны байдлаар сумын нутаг дэвсгэрт АМ-ын хайгуулын 27, ашиглалтын 4 тусгай зөвшөөрөл, Ашигт малтмалын лицензийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтад оруулла.

| | Тусгай зөвшөөрлийн тоо | газар нутагт эзлэх хувь | тусгай зөвшөөрөл эзэмшигч компаны тоо |
|---|---|---|---|
| Хайгуулын | 27 | | 24 |
| Ашиглалтын | 4 | | 4 |
| БУЭ иргэд | 1 | | |
| Бүгд | 32 | | 28 |

2015 онд Орон нутгийн тусгай хамгаалалтанд 6 байршилд нийт 919271,67 га газрыг авч АМГ-ын Кадастрын бүртгэлд бүртгүүлж, замбараагүй лиценз олголт, дээж авах нэрийдлээр ашигт малтмал олборлох явдлаас урьдчилан сэргийлж, даац хэтэрсэн бэлчээрээ хамгаалах арга хэмжээ авсан байна.

*Нөхөн сэргээлтийн талаар*:

| | Техникийн нөхөн сэргээлт | | Биологийн нөхөн сэргээлт | |
|---|---|---|---|---|
| | Хэмжээ га талбай | Он | Хэмжээ га талбай | Он |
| Том уурхай | | | | |
| Бичил уурхайн ТББ | 17 | 2013 | 17 | 2013 |
| | 1,5 | 2014 | 1,5 | 2014 |
| | 10 | 2015 | 10 | 2015 |
| **Дүн** | **28,5** | | **28,5** | |

### 3.8. Агаарын бохирдол, ногоон байгууламж

Өвөл, хаврын улиралд 2015 оноос өмнө сумын төвд аж ахуйн нэгж байгууллагуудын 12 ширхэг нам даралтын зуух ажиллаж жилдээ 380 тн орчим нүүрс түлдэг байсан бол 2015-2016 онд төвийн нэгдсэн халаалтын шугамд холбогдсоноор нэгдсэн халаалтын 1 уурын зуух ажиллаж жилд 300 тн нүүрс хэрэглэж байна. Гэр хорооллын хувьд 120 гаруй айл өрх 600 тн орчим нүүрс хэрэглэж байна. Сумын хэмжээнд 300 гаруй автомашин байгаагаас сумын төвд 100 орчим автомашин байдаг.

Энэхүү нүүрс болон авто машинаас ялгарч буй их хэмжээний нүүрс хүчлийн хий агаарыг ихээр бохирдуулж байна гэж үзэж байна.

[4] - эх сурвалж
[5] - “Өлзийтийн хөгжил 2009-2020” хөгжлийн төлөвлөгөө. 16-р тал. 2009 он.

Ногоон байгууламжийн хувьд нийт 5,2 га талбайд улиас, шар хуайс, чацаргана, хайлаас, бургас, улаан сухай, үхрийн нүд зэрэг мод, суулгацыг тарьж ургуулж байгаа ба энэ нь 70-80 хувийн ургалттай байна.

Дараах хүснэгтээр харуулбал:

| **Ногоон байгууламж бүхий обьектийн нэрс** | **Ногоон байгууламж бүхий талбайн хэмжээ /га/** | **Модны тоо** |
|---|---|---|
| ЗДТГ | 0.3 | 745 |
| Эрүүл мэндийн төв | 0.2 | 29 |
| ЕБСургууль | 0.5 | 40 |
| Дотуур байр | 0,3 | 15 |
| Төв талбай | 0.3 | 92 |
| Хойд талбай | 2,5 | 1703 |
| Айл өрхүүд | 0,1 | 170 |
| **Нийт** | **5,2** | **2794** |

### 3.9. Хог хаягдал

Сумын төв дэх төвлөрсөн халаалтаас 5-н албан байгууллага, орон сууц бүхий 44 өрх халаалт авдаг. Гэр орон сууцанд 120 гаруй өрх оршин амьдарч жилд нүүрсний болон бусад хог хаягдлаар 820 орчим тн ахуйн хог гаргаж төвлөрсөн хогийн цэгт зайлуулдаг. Хойноосоо урагш сунаж тогтсон 3 га хог хаягдлын талбайтай.

Сумын нэгдсэн хогийн цэгийг 2013 онд Орон нутгийн хөгжлийн сангийн 15 сая төгрөгний хөрөнгөөр тухайн хогийн цэг орчмын 8 га газрын тарааж асгасан хогийг багасгаж 3 га газар болгон шууж хүрээ үүсгэж далан босгож, хаалга хийсэн.

### 3.10. Соёлын өвийн хамгаалал



Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт Загийн усны байгалийн нөөц газар, Уул Хадарганатай, Цагаан суварга, Хэвтээ босоогийн агуй, Дэл, Хөнжлийн уул, Өөш манханы элс, Монтойн хайлааст ам, Морин толгойн цав, Хонгор хайрхан, Бан цохио зэрэг байгалийн үзэсгэлэнт, цогцолбор газруудаас гадна 1930-аад оны их хэлмэгдүүлэлтийн үеийн гэрч болон үлдсэн Хөнжил уулын Далай, Хар ноён, Булаг билүүн, Эрдэнэ баян, Цагаан хад, Гучин, Тал, Хөтөл, Бор-Овоо зэрэг олон сүм, хийдийн туурийн балгас өнөө цагийн соёлын өв болон үлдсэн байдаг.

Мөн хүн төрөлхтөний түүх, соёл, бичиг үсгийн хосгүй нандин өвийн нээлттэй нэгэн галлерей сумын төвөөс баруун урагш 80 км-т байх хад болгон дээрээ соёлын дурсгалтай Дэлийн уул болно. Энэхүү байгалийн галлерейгаас товч дурьдвал:

Тус уулын Баруун билүүний орчмын “**32 хүнт**” буюу эртний түрэгийн үеийн буган хөшөө, хирэгсүүрүүд, Зүүн билүүний хаданд манай тооллын 630-аад оны үед бичигдсэн эртний түрэг бичээс, 660-аад оны үед бичигдсэн хятад ханз бичээс, эртний Руни бичээс зэрэг олон янзын бичгийн төрөл байхаас гадна хүн, гэр, морь тэрэг, буга, янгир зэрэг олон төрлийн амьтдын дүрс бүхий эртний хүн төрөлхтөний соёл, ахуй, заншлыг харуулсан хадны

| | |
|---|---|
| | зургууд байна.<br>Эдгээр түүх, соёлын дурсгалуудаас гадна эрдэм шинжилгээний болон түүх, домог, яруу найргийн маш олон тооны оюуны бүтээлүүд гарсан байдаг ба энэ бүгдийг энд хамруулж болно.<br>   |

## 3.11. Эдийн засгийн голлох салбарууд

| | |
|---|---|
| Сумын нийгэм, засгийн төлөв байдал | **3.11.1. Мал аж ахуйн салбар**<br>Сумын эдийн засгийн хөгжлийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд эрт дээр үеэс өвөг дээдэс маань өргөн уудам нутагтаа бэлчээрийн мал аж ахуйгаа хөгжүүлсээр ирсэн түүхтэй юм. Сумын хэмжээнд 2015 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр **202459** толгой мал тоологдсон байна. Үүний **4,85%-**ийг тэмээ, **2,94%-**ийг адуу, **0,61%-**ийг үхэр, **41,96%-**ийг хонь, **49,63%-**ийг ямаа тус тус эзэлж байна.<br><br>Сүүлийн жилүүдэд тэмээгээ 10.000 толгойд хүргэн өсгөх зорилт тавин ажиллаж 2016 онд “**Нэг түмэн тэмээ**”-ний баяр зохион байгууллаа. Тус сум нь тэмээгээ Ханийн хэцийн хүрэн, Галбын говийн улаан үүлдрийн тэмээгээр, адуугаа Сүхбаатар, Галшар чиглэлийн адуугаар, хонин сүргийн махан ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор Үзэмчин, Барга омгийн хээлтүүлэгч ашиглан тус тус сайжруулж байна. Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх чиглэлээр мах, сүүний чиглэлийн үхэр үржүүлж, сумын төвийн иргэдийг сүү, цагаан идээгээр хангаж эхлээд байна.<br>**3.11.2. Уул уурхайн салбар**<br>Тус суманд ашиглалтын лиценз эзэмшигч 4 аж ахуйн нэгж, Хайгуулийн лиценз эзэмшигч 27 ААН, 1 талбайд жоншны бичил уурхайн 6 нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна. Нийт нутгийн **15.3 хувьд** уул уурхайн хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байна.<br><br>**3.11.3. Аялал жуулчлалын салбар**<br>Тус сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн 2 жуулчны бааз, Өөш манханы элс түшиглэн 1 сувилалын газар үйл ажиллагаа явуулахаас гадна “Гэрээс гэрт” жуулчны сүлжээнд 2 өрх хамрагдсан. |

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ БОЛОН ЭРСДЭЛ, ТҮНИЙ ЗЭРЭГ, ТАЛУУД ХООРОНДЫН ХАРИЛЦААГ ТОДОРХОЙЛСОН ҮНЭЛГЭЭ

### 4.1. Сумын эдийн засгийн голлох салбарууд, тэдгээрийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, түүний зэрэг

| Эдийн засгийн үйл ажиллагаа | 2.БО д үзүүлэх нөлөөлөл/ асуудал | **3. Нөлөөллийн** зэрэг[6] | 5. Өртөгч талууд |
|---|---|---|---|
| Мал аж ахуй | **Бэлчээр талхлагдал** /3-р баг Хужирт, Хонгилын зоо, Буурал, Загийн ус, Тал, 5-р баг Модон, Өсөх, Цагаан толгойн номгон 4-р баг баруун булаг, зүүн булаг, 3 төгрөг, төхөм,зах сүүж, солгой / нийт нутаг дэвсгэрийн 20-30% **Бэлчээрийн даац хэтрэлт:/**Малын тоо толгой ихээр өссөн | Дунд зэрэг | **Ургамал, ан амьтан**- Ургамлын гарц муудах, төрөл зүйл цөөрөх, цөлжилт бий болох, хээрийн болон /цагаан зээр / зэрлэг амьтан хорогдох |
| | Усны эх бохирдол /Хөөврийн булаг, Баруун билүүний булаг, Даамайн булаг,булаг хармагтайн булаг , Солгойн булаг, Баян булаг, Рашаант / | Дунд зэрэг | Малчид, ан амьтан, ургамал усны эх бохирдосноос мал амьтан усаар дутах ус ширгэх зэрэг асуудал гарах |
| | Усны хомсдол /Сайн билүүн, муу билүүн, шинэ ус, тагт, шарангад, рашаант, үнэгэд, уул худаг , худаг сүүж, замын сүүж, хүрэн цавын шанд, хөөвөр, дэртийн хүрэн овоо, нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй худаг / | Аюултай зэрэг | Малчид, ан амьтан, малын тоо өссөнөөр усны хүрэлцээ муудах |
| | Ургамлын тоо цөөрөх /Хөтөл, гурван ухаа, хужир тээг, билүүн, тойрмын хар, ембүү, шарангад, нүхт, хөнжил, буянтын зүүн төгрөг байгалийн хүчин зүйл байгалийн бус хүчин зүйл/ /анхаарах/ бэлчээрийн доройтол | дунд зэрэг | Амьтан, шавьж ургамалын төрөл зүйл цөөрч, ургамалын ургалт удаашрах |
| | ТХГ нутаг | Бага зэрэг | Ан амьтан, ургамал. |
| | Малаас хүнд халдах өвчин | Бага зэрэг | Иргэд, малчид. |
| | Бэлчээрийн даац хэтрэлт хөрсний доройтлын | Бага зэрэг | Ургамал, ан амьтан. Байгаль унаган төрхөө алдах. |
| | Хөрсний элэгдэл | Бага зэрэг | Ургамал, мал амьтан, шавьж |
| | Олон салаа зам | Бага зэрэг | мал, ургамал |
| Бичил уурхай хамо иргэд | - Хөрс доройтуулна /Ембүү, Шарангад, Хөтөл, Гурван-Ухаа, Шар хошуу, Хөнжил, Шар уул / | аюултай | Малчид, иргэд, |
| | - Агаар, хөрсний бохирдол /хог, тоос/ | Дунд зэрэг | Ургамал, ан амьтан, малчид |
| | - Бэлчээрийн доройтол /олон салаа зам, тоосжилт/ | өндөр | Ургамал, ан амьтан, малчид |

6- Нөлөөллийн зэргийг үнэлэхд эрсдлийн аргыг ашиглана.

| | | | |
|---|---|---|---|
| | - Усны хомсдол /булаг шанд ширгэх/ | Бага | Ургамал, ан амьтан, малчид, |
| | - | | иргэд |
| | | | |
| | - Ан амьтан дайжих | Бага | |
| | - Ургамлын төрөл зүйл /эмийн ургамал, г.м/ | Дунд зэрэг | Үндэс цөөрнө |
| | - Заган ойн эрсдэл | Дунд зэрэг | Ан амьтан, малчид |
| | - Соёлын өв устах эрсдэл /Дэл уулын хадны зураг, Далайн хийд, Баруун бүлүүнийн хийд, 32 хүн чулуут булш г.м/ | Аюултай | Түүхийн эх сурвалж бүдгэрэх, жуулчид багасах |
| Уул уурхай лиценц эзэмшигчид | Ураны хайгуул, Нүхт, Цант, Говийн хөхийн жоншны уурхайнууд, Үнстийн нүүрсний уурхай | Аюултай | Малчид, иргэд , ан амьтад |
| | Хөрсний доройтол /газрын хэвлийн эвдрэл, нөөцийн хомсдол, олон салаа замууд, отвол / | Аюултай | Ан амьтад ,малчид, ургамал |
| | Орчны бохирдол /агаарын бохирдол, хог хаягдал/ | өндөр | Ургамал, |
| | Усны хомсдол /уурхайн ойр орчмын гүний болон хөрсний ус устаж үгүй болох, булаг шанд ширгэх/ | Аюултай | Ан амьтад ,малчид, ургамал |
| | Эзэнгүй талбай, нүх, цооног үлдэх | Аюултай | Ан амьтад ,малчид, ургамал |
| | Малчдын өвөлжөө хаваржаа устах | өндөр | Малчид |
| | Ан амьтад дайжих, тоо толгой нь цөөрөх | Дунд зэрэг | Ховордсон ан амьтад, цөөрөх |
| Барилга, зам, дэд бүтэц | Тоосжилт | Бага | Хүн малын эрүүл мэндэд хор нөнөөлтэй |
| | Салаа зам гаргах, | Аюултай | Хүн, мал амьтан, ургамал нөлөөлнө. |
| | Элс хайрга чулуу ашиглах /карьерын нүхтэй болох/ | Аюултай | Хүн, Мал амьтанд маш их аюултай /экологийн унаган төрх бүр мөсөн алдагдана. |
| | Хөрсний доройтол | Өндөр | Хүн, мал амьтан, ургамал нөлөөлнө. |
| | Барилгын Хог хаягдал | Дунд зэрэг | Хүн, Мал амьтан, ургамал, /элдэв өвчин үүсэх аюултай/ |
| | Цэвэршүүлэх байгууламж | Дунд зэрэг | Хойшид ашиглагдах |
| Аялал жуулчлал, | Хог хаягдал /цагаан суврага, дэл уулын зам дагуу, мөн өөшийн сувилалын зам дагуу/ | Дунд зэрэг | Хүн, Мал амьтан, ургамал, /элдэв өвчин үүсэх аюултай/ |
| | Тоосжилт /аймаг сумын төвөөс дээрх газрын чиглэлийн зам дагуу/ | Бага | Хүн малын эрүүл мэндэд хор нөнөөлтэй / |
| | Маршрутын бус зам гаргах /зэрэгцээ зам олон гаргаж байгаа/ | Аюултай | Задгай булаг шанд, Бэлчээрийн ургамалд, муу нөлөөтэй/ан амьтан даажих/ |

| | | | |
|---|---|---|---|
| түүхийн дурсгалт газар | Орчны газрын элэгдэл гарах/цагаан суваргын жуулчны бааз, өөшийн сувилалын орчинд / | Аюултай | Маш их тоосжилттой болох, ба Ургамлын ургах нөхцөл, орчны эрүүл ахуйг доройтуулна. |

**Дүгнэлт:**

I. Сумын нутаг дэвсгэр дэх байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн бүхий л салбарын үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөллийг эрчим өндөртэйгээр үүсгэх байдал ажиглагдаж байна. Эдийн засгийн салбарын үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөл нь биологийн төрөл зүйлд түүний амьдрах орчинд илүү сөрөг нөлөөлөл үзүүлж энэ нь улмаар эдийн засгийн бусад салбаруудын тогтвортой хөгжих боломжуудыг хязгаарлах магадлал үүсгэж байна.

II. Тухайлбал, **Аюултай зэрэглэлд:**

1. МАА салбараас:
   - Усны хомсдол /Сайн билүүн, муу билүүн, шинэ ус, тагт, шарангад, рашаант, үнэгэд, уул худаг , худаг сүүж, замын сүүж, хүрэн цавын шанд, хөөвөр, дэртийн хүрэн овоо, нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй худаг /
2. БУ-н үйл ажиллагаа:
   - Хөрс доройтуулна /Ембүү, Шарангад, Хөтөл, Гурван-Ухаа, Шар хошуу, Хөнжил, Шар уул /
   - Соёлын өв устах эрсдэл /Дэл уулын хадны зураг, Далайн хийд, Баруун бүлүүнийн хийд, 32 хүн чулуут булш г.м/
3. Том уул уурхайн үйл ажиллагаа:
   - Ураны хайгуул, Нүхт, Цант, Говийн хөхийн жоншны уурхайнууд, Үнстийн нүүрсний уурхай
   - Хөрсний доройтол /газрын хэвлийн эвдрэл, нөөцийн хомсдол, олон салаа замууд, отвол /
   - Усны хомсдол /уурхайн ойр орчмын гүний болон хөрсний ус устаж үгүй болох, булаг шанд ширгэх/
   - Эзэнгүй талбай, нүх, цооног үлдэх
4. Дэд бүтэц зам баригдах:
   - Салаа зам гаргах,
   - Элс хайрга чулуу ашиглах /карьерын нүхтэй болох/

5. Аялал жуулчлалын салбар:
   - Маршрутын бус зам гаргах /зэрэгцээ зам олон гаргаж байгаа/
   - Орчны газрын элэгдэл гарах/цагаан суваргын жуулчны бааз, өөшийн сувилалын орчинд / тус тус хэт өндөр эрсдэл үзүүлж байгаа нь матрицаас харагдаж байна.

Иймд аюултай болон их гэсэн зэрэглэлд тодорхойлогдсон хэсгүүдийг эхний ээлжинд онцгой анхаарч менежементийн төлөвлөгөөнд тусгаж, эхний жилүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтааж хариу арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байна.

Өлзийт сум өргөн уудам нутагтай тул усны нөөцийг нэмэгдүүлэх боломжийг хайж, арга хэмжээ авснаар бэлчээрийн усны хомсдолыг сааруулах боломжтой байж болно. Харин Оюу толгой төслийн гүний усны хэрэглээ нь Өлзийт сумын гүний болон хөрсний усны түвшинд нөлөө үзүүлж байгаа эсэхийг судлан тогтоох шаардлага гарч байна.

### 4.2. Байгаль орчны асуудал ба оролцогч талууд, тэдгээрийн харилцаа

| **Оролцогч талууд** | **Малчид** | **БУЭ иргэд\ нөхөрлөл\ ТББ** | **Том уурхай** | **Бизнесмен** | **Мянгат малчид** | **ХАМО/хувиараа ашигт малтмал олборлогчид/** |
|---|---|---|---|---|---|---|
| Малчид | Ихэнх тохиолдолд зөрчил үүсэхгүй | БУ-н үйл ажиллагааны болон тээвэрлэлтийн замын ойролцоох бэлчээр, бууц хороо | төвөгтэй | Хамтарч ажилладаг | Хороо бууцны эзэмшил, Бэлчээр, усны асуудлаас зарим тохиолдолд зөрчил үүсдэг | Нинжа нар зөвшөөрөлгүй газар алт хайж ухаж сүйтгэснээс бэлчээр, худаг ус, хороо бууцны зөрчил маргаан гардаг |
| Мянгат малчид | Хороо бууцны эзэмшил, Бэлчээр, усны асуудлаас зарим тохиолдолд зөрчил үүсдэг | Төвөгтэй | Аюултай | Хамтарч ажилладаг | Эерэг | Аюултай |
| БУЭ иргэд | БУ-н үйл ажиллагааны болон тээвэрлэлтийн замын ойролцоох бэлчээр, бууц хороо | Нэгдсэн зохион байгуулалтад орж, иргэдийг ажлын байраар хангаж ажиллаж байна. | Дунд зэрэг | Хамтарч ажилладаг, Дэмжигч | төвөгтэй | Дунд зэрэг |
| Том уурхай | Төвөгтэй | Төвөгтэй | Газар нутгийн хувьд маргаангүй тохиолдолд зөрчил үүсэхгүй. | Хамтарч ажиллахыг эрмэлздэггүй | Аюултай | төвөгтэй |
| Бизнесмен | нөлөөгүй | Хамтарч ажилладаг, Дэмжигч | Хамтарч ажиллахыг эрмэлздэггүй | Зах зээлийн өрсөлдөөний зарчмаар ажилладаг | Хамтарч ажилладаг | Олборлосон ашигт малтмалаа хямд үнээр, хууль бусаар наймаалцдаг |
| ХАМО /хувиараа ашигт малтмал олборлогчид / | Аюултай | Дунд зэрэг | Дунд зэрэг | Олборлосон ашигт малтмалаа хямд үнээр, | Аюултай | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хууль бусаар наймаалцдаг | | |

**Дүгнэлт:**

1. Энэхүү матрицийг ашиглан байгаль орчны оролцогч талуудын харилцааг холбогдох нүдэнд бөглөсөн харилцаанаас харахад ашигт малтмалын нөөцийн ашиглагч талууд бусад эдийн засгийн саларынхантай ялангуяа үндсэн эдийн засгийн салбар болох МАА, аялал жуулчлалын салбартай аюултай буюу төвөгтэй зөрчилдөөнтэй байх тал илүү харагдаж байна.
2. Харин бизнесийн үйл ажиллагаа бүх талуудтай эерэг харилцаатай байна.
3. Малчид дотроо малын тооноос хамаарч зөрчилтэй байх тал ажиглагдаж байна.

### 4.3. Байгалийн нөөцийг ашиглагч талуудын зөрчилдөөн түүнд арга хэмжээ авах үүрэг хүлээгчид

| Зөрчилдөөн болон үүрэг хүлээгч тал | Засаг дарга | ИТХ | БОУБ-гч | БУ ТББ “Өлзийт хишиг буян” | Багийн Засаг дарга |
|---|---|---|---|---|---|
| Малчид- бичил уурхай, Том уурхай, ХАМО хоорондын зөрчил | +++ | +++ | + | ++ | ++ |
| БУЭ- том уурхай- ХАМО-малчид хоорондын зөрчил | +++ | ++ | + | ++ | ++ |
| Иргэд, аялал жуулчлалын зөрчил | +++ | + | ++ | | ++ |

**Дүгнэлт:**

1. Байгаль орчин, байгалийн баялаг, нөөцийг ашиглагч бүх талуудад зөрчил байгаа нь харагдаж байна. Үүнийг зохицуулахад хамгийн их оролцоотой талуудын үүрэг хариуцлага, оролцооны хэр хэмжээг (+) …. (+++) тэмдгээр илэрхийлнэ. Өлзийт сумын хувьд үндсэн 2 талын зөрчил байна. Үүнд:
2. **Малчид, мянгат малчин- Бичил уурхай, Том уурхай, ХАМО иргэд хоорондын зөрчил** нь хөрсний дортойтол нь бэлчээрийг хосдуулдаг, олон салаа зам гаргадаг нь ургамлын бүрхэвчийг бохирдуулдаг, өвөлжөө, хаваржааны газрыг бохирдуулж, хөрсний эвдрэл үүсгэдэг гэж үздэг байна. Оролцогч талуудын маргааныг зохицуулах үүрэг хүлээгч тал нь Засаг дарга, БОУБ, ТББ
3. **Бичил уурхай, Том уурхай, ХАМО иргэд - Малчид, мянгат малчин- хоорондын зөрчил** нь мөн хуулийн дагуу авсан талбай, ицензийн талбайд зохих эрхийн дагуу үйл ажиллагаа явуулахдаа олон салаа зам гаргах, өвөлжөө хаваржааны орчим хэи ойрхон өнгөрөх, малын бэлчээрийн ургамлыг машин замаар налуулж бохирдуулах, ашиглалт явуулсан газраа нөхөн сэргээхгүй үлдээх зэрэг нь малчидтай зөрчилдөх гол шалтгаан болж байна. ХАМО иргэдийн хувьд ямар ч нөхөн сэргээлт хийхгүй ухсан нүх, овоолсон шороо үүсгээд алга болдог, түүх соёлын өвийг хулгайлах, ухаж байгаа нь зөрчилдөөн үүсгэж байна.

Иймд тодорхой арга хэмжээ авч болохуйц харьцангуй цөөн талуудын зөрчил байгаа тул сумын удирдлагаас тодорхой хяналт, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогоох зэргээр хариу арга хэмжээг БОМТ-д тусгаж жил бүрийн төлөвлөөнд тогтмол тусгаж байх шаардлага гарч байна.

## 4.4. Байгалийн нөөцийг ашиглагч талууд ба үнэт зүйлс хоорондын харилцаа

| Оролцогч тал\ БО ны бүрэлдэхүүн хэсэг | Аргаль, янгир, зээр, чоно, шилүүс г.м | Байгалийн нөөц, баялаг / ашигт малтмал, ховор эмийн ургамлууд, сувиллын элс, булаг шанд, бэлчээр, ус/ | Улсын болон ОНТХ-тай газрууд /Загийн ус, Дэл уул, Цагаан суварга, Өөш манхан, Морин толгойн цав/ | Археологийн олдворууд /чулуужсан мод, үлэг гүрвэлийн өндөг, яс, түүх, соёлын өвүүд/ |
|---|---|---|---|---|
| **Малчид** | Хулгайн ан хийдэг | | | Гадны хүмүүст мэдээлэл өгч хиригсүүр, булш хамтарч ухдаг |
| **ХАМО** | Хулгайн ан хийдэг | Ухаж сүйтгэх магадлалтай | Тусгай хамгаалалттай газар нутагт дураараа ашигт малтмал болон соёлын өвийн үнэт зүйлсийг ухаж сүйтгэдэг, Заг, бутлаг ургамлыг дураар түүж түлдэг | Хайгч багажны тусламжтай хиригсүүр, булш ухдаг, сүйтгэдэг |
| **Бичил уурхай** | | Тээвэрлэлтээс үүдэлтэй бэлчээр, хөрсний доройтол үүсгэдэг | | |
| **Том уурхай** | Үргэж дайжих усаж үгүй болох | Газрын гүний болон хөрсний усны нөөц, судлыг гэмтээдэг, зүй бусаар хяналтгүй ашигладаг | | |

**Дүгнэлт:**

1. Энэхүү матриц судалгаанаас хархад ХАМО-Түүхийн дурсгалт газар, ХАМО-Орон нутгийн тусгай хамгаалтай газар, ХАМО-өгөт чулуу, дэд бүтэц-ан амьтан  зэргийн харилцаа нэн тэргүүнд арга хэмжээ авах шаардлагатай байна.

### 4.5. Сумын байгаль орчны өнөөгийн төлөв байдалд хийсэн СВОТ дүн шинжилгээ

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| • Газар нутгийн хэмжээ том<br>• Мал сүрэг олон, тэмээний тоо толгойгоор аймаг, улсад тэргүүлдэг<br>• Отрын бүс нутагтай<br>• Малын халдварт өвчин харьцангуй бага гардаг<br>• Газар тариалан эрхлэх газар нутагтай<br>• Ашигт малтмалын нөөц ихтэй<br>• Заган ой бүхий бүс нутагтай<br>• Сумын төвийн дэд бүтэц /нэгдсэн халаалттай болсон/<br>• Аялал жуулчлалыг хөгжүүлэх байгалийн үзэсгэлэнт газар олонтой<br>• Төрөл бүрийн эмийн ургамлын арвин нөөцтэй<br>• Эмчилгээний чанар бүхий рашаан, шавар, элстэй | • Бэлчээрийн усан хангамж муу<br>• Малын хулгай их, хуулийн хэрэгжилт хангалтгүй<br>• Газар тариалан хөгжөөгүй<br>• Цөлжилт ихсэж байгаа |
| **Боломж** | **Саад бэрхшээл** |
| • Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх<br>• Мал эмнэлгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж, эм тарилга оруулж ирэх<br>• Өрхийн тариаланг нэмэгдүүлэх<br>• Цөлжилтийг сааруулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх<br>• Бичил уурхайг хөгжүүлэх, иргэдийн орлого нэмэгдэх<br>• Уул уурхайн үйл ажиллагаа болон ХАМО-оос хамааран эвдэгдсэн газруудыг нөхөн сэргээх<br>• Малчдын бүлэг хоршоог нэмэгдүүлэх<br>• Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, зэрэглэлийг нэмэгдүүлэх /улсын болон аймгийн тусгай хамгаалалтад авах/<br>• Зэргэлдээ орших сумдтай хамтран ажиллаж хилийн цэс тогтоох, тодруулах<br>• | • Хөдөө аж ахуйн салбар цаг агаараас шууд хамааралтай хэвээр байх<br>• Шороон шуурга, ган зудын аюул нэмэгдэх<br>• Мал, амьтны халдварт өвчин гарах<br>• Байгальтай зүй бус харьцсанаас экологийн тэнцвэр алдагдах<br>• Ашигт малтмал олборлогчид нөхөн сэргээлт хийхгүй байх<br>• Малчдын байршил тархуу, алслагдмал<br>• Хөрсний болон замын эвдрэл ихсэх<br>• Иргэдийн экологийн ухамсар хандлага муу<br>• Хог хаягдлын менежмент муу<br>• Ан агнуурын бүс нутгийн менежментийг сайжруулах<br>• Усан хангамжийг нэмэгдүүлэх<br>• Заган ойн нөхөн төлжүүлэх<br>• Рашаан, сувилал хөгжүүлэх |

**Дүгнэлт:**

Орон нутгийн давуу талыг ашиглан, сул талыг давуу тал болгон бэрхшээлийг арилгаж шийдвэрлэхийн тулд дараах ажлуудыг холбогдох менежментийн төлөвлөгөөнд нэмэлтээр оруулах нь шаардлагатай байна.

1. Газар ашиглалтын менежментийн төлөвлөгөөнд: Бэлчээрийн усан хангамж муу тул газар нутгийн ус, худаггүй талбайд худаг ус гаргах замаар бэлчээрийн ашигалтыг нэмэгдүүлэх

2. Усны менежментийн төлөвлөгөөнд: Гүний усны судалгааг хийлгэж, худаг усны тоог нэмэгдүүлэх, Говийн бүсэд хэрэгжиж байгаа уул уурхайн томоохон төслүүдийн нөлөөлөлд Өлзийт сумын эко систем хамаарч байгаа эсэх талаар судалгаа хийлгэх
3. Соёлын өвийн менежментийн төлөвлөгөөнд: Түүх соёлын өв, археологийн олдворыг бүрэн бүртгэлжүүлэх, хамгаалалтанд авах, Хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах,
4. Байгаль орчны бусад асуудлуудын менежментийн төлөвлөгөөнд: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах, иргэдийн экологийн боловсролыг сайжруулах, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хариуцлагыг сайжруулах, хяналтыг чангатгах, ногоон байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, түүх соёлын өвийг хамгаалж аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийг БУЭ үйл ажиллагаанаас аль болох татгалзуулж ногоон ажлын байрыг бий болгохыг дэмжих, боломжуудыг нээж өгөх, цөлжилтийг бууруулах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, дүйцүүлэн нөхөн сэргээлт явуулах,
5. Биологийн олон янз байдлын болон тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд: Биологийн олон зүйлийг хамгаалах төлөвлөгөөг нарийн зохион байгуулах, хулгайн ан хийхтэй тэмцэх, иргэдийн ухамсар хандлагыг нэмэгдүүлэх, ан агнуурын бүс нутгийн хязгаарыг тогтоох, нутгийн ургамал ялангуяа заган ойн хүрээг тэлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, ангилал зэрэглэлийг ахиулах
6. Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талуудыг чадавхижуулах менежментийн төлөвлөгөөнд: Өлзийт нутгийн иргэдэд нутгаа гэсэн өөриймссөн сэтгэлгээг суулгаж өгөх, ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт эко аялал танилцах экскурсыг төлөвлөж оруулах, ИТХ-ын төлөөлөгчид өөрийн тойргийн иргэдэд БОМТ-г ухуулан таниулах замаар тэдний үүрэг оролцоог ойлгуулах, хариуцлагатайгаар байгалийн нөөцийг ашиглах мэдлэг, мэдээлэл өгөх, иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгаа хийх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ажлыг системтэйгээр зохион байгуулах талаар тус арга хэмжээнүүдийг төлөвлөх нь зүйтэй байна. Энд мэргэжлийн хүмүүсийн оролцоог ихээхэн хангаж тэдэнд түшиглэж хэрэгжүүлэх шаардлагатай.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОМТ-НИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ЗАМУУД

**Тав. Байгаль орчны менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөө**

**5.1. Газрын менежементийн төлөвлөгөө**

| Сөрөг нөлөөлөллууд | Зайлсхийх, бууруулах, арилгах төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Байгаль хамгаалах бусад төлөвлөгөө, бодлоготой уялдсан байдал | нийт зардал, эх үүсвэр | шалгуур үзүүлэлт | хариуцах тал |
|---|---|---|---|---|---|---|
| <u>Бэлчээр талхлагдал:</u> Малын тоо толгой ихээр өссөн, бэлчээрийн хуваарилалтгүй ашиглалтаас Бэлчээрийн даац хэтрэлт зарим газар үүссэн | • Нутгийн ихэнх нутгаар малчидыг тарж нутагшуулах, хороо бууцыг эзэмшүүлэх.<br>• Гүний болон энгийн худгийг бэлчээрийн зүй зохистой газарт гаргах.<br>• Бэлчээрийн даацыг тооцон доройтолд орсон бэлчээрийг сэлгэх, өнжөөх арга хэмжээ авах.<br>• Бэлчээрийг хаших арга хэмжээ авах.<br>• Бэлчээр ашиглах журмыг мөрдүүлэх.<br>• Нүүдлийн мал аж ахуйн уламжлалт зан заншил сургалт сурталчилгаа хийж хойч үедээ өвлүүлэн үлдээх өдөр тутмын амьдралдаа мөрдөж амьдардаг зөв дадал зуршилд сургах. | Жил бүр<br><br>Жил бүр<br><br>2016 он<br><br>2016 он<br><br>Жил бүр | ЗД-ын захирамж, ИТХТ-ын тогтоол<br><br>Ус үндэсний хөтөлбөр ЗГ-ын 1999 оны 43 дугаар тогтоол<br><br>Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөр БО-ны сайдын 2001 оны 247 дугаар тушаал.<br><br>“Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-тэй нийцнэ<br><br>“Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” тэй нийцнэ | Олон улсын байгууллага төсөл хөтөлбөр ОУБ болон төсөл хөтөлбөр. | Одоогийн эзэнгүй байгаа бэлчээр нутагт баригдсан худгийн тоо, суурьшсан малчдын тоо<br><br>Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гаргасан байна<br><br>Малчдын нөхөрлөл бүлгүүд бэлчээрийг хуваарьтай ашигладаг болсон байдал<br><br>Хашсан талбайн хэмжээ тоо | Малчдын бүлэг, ЗД, газрын алба<br><br>Малчдын бүлэг, нутгийн захиргааны байгууллага |
| <u>Хөрсний бохирдол,</u> | • Техник, биологийн | | Төрөөс экологийн | Олон улсын | Газрын гадаргуу | ЗДТГ, иргэд, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| <u>доройтол:</u> Сүүлийн жилүүдэд бичил уурхайн үйл ажиллагаанаас олон төрлийн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихэсч олон салаа зам үүсгэж байгаа нь хөрсний бохирдол, доройтлыг үүсгэж байна. бичил уурхайн үйл ажиллагаа нөхөн сэргээлт хийгүйгээс Шарангад, Нүхтийн жонш, Өлзийт 1 газруудад илүү байна. | нөхөн сэргээлт хийхэд хяналт тавьж, тодорхой төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх<br>• Нийт нөхөн сэргээх шаардлагатай газруудыг солбицлын цэгийг гаргах. | 2016-2021 | талаар баримтлах бодлого УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоол “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”- Тогтвортой хөгжил зорилтууд 2030 бодлого, Ногоон хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжинэ | байгууллага төсөл хөтөлбөр, орон нутгийн, болон улсын төсөв. | унаган төрхөндөө орсон байх<br>Хөрс ургамал сэргэх, ургах Чадавхижсан байх<br>Ажлын байр нэмэгдэх орон нутгийн санд тодорхой хэмжээний орлого орно | |
| <u>Хөрс доройтуулна:</u> **/Ашигт малтмалын түүхий эдийн тээвэрлэлт, уурхай болон суурин газарт зорчих автотээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хог хаягдлын хэмжээ-** *Цагаан дэвсэг, Гурван ухаа, Хошуу хонд* | • Авто замын маштрутыг ИТХ-р баталж гарган нэг замаар явуулж мөрдүүлэх.<br>• Уул уурхай компаниудаас гарсан хог хаягдлыг төвлөрсөн нэг цэгтэй болгох. | 2016-2021 | ИТХ-ын тогтоолоор гарсан замын маршрут 2015 он<br>Хог хаягдлыг бууруулах тухай үндэсний хөтөлбөр ЗГ-ын 1999 оны 50 дугаар тогтоол. | Тухайн байгууллагуудын өөрийн хөрөнгөөр. | Лицензийн тоо буурсан байна<br>Хаягдал гаргахгүйгээр байгалийн баялагийг ашиглах | ЗДТГ, |
| <u>Хөрсний доройтол:</u> **/Тоос шороо их** ***/элсний нүүдэл/,*** **хур бороогүй байдал, дэлхийн дулаарал, ган зуд-***/Нийт нутгаар/* | • Цөлжилтийн эсрэг мод ургамал тарих<br>• Ногоон байгууламжыг нэмж байгуулах.<br>• Дуйцүүлэн нөхөн сэргээх газрыг тогтоож ойжуулах | Жил бүр | Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2002 оны 105 дугаар | Төсөл хөтөлбөр, Байгаль хамгаалах сан Хувийн хэвшлийн хөрөнгө | Цөлжилтийг бууруулахад зарцуулсан төсөв, арга хэмжээ | ЗДТГ, иргэд |

## 5.2. Усны менежментийн төлөвлөгөө

| сөрөг нөлөөллүүд | Зайлсхийх, бууруулах, арилгах төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | байгаль хамгаалах бусад төлөвлөгөө, бодлоготой уялдсан байдал | нийт зардал, эх үүсвэр | шалгуур үзүүлэлт | хариуцах тал |
|---|---|---|---|---|---|---|
| Усны эх, түүний орчмын бохирдол: **/Ус ашиглагчийн буруу үйл ажиллагаа болон малчдын хайхарамжгүй байдал, худгийн барилгын эвдрэл,гэмтэл/** | -Инженерийн хийцтэй худгийг гэрчилгээжүүлэх<br>-малчид, малчдын бүлэгт гэрээгээр эзэмшүүлэх, засвар үйлчилгээ хийхэд урамшуулах<br>--төв, суурингийн усанд ариун цэвэр хамгаалалтын бүс тогтоох<br>-Уст цэгийн тооллого хийх, чанар байдлыг тогтоох<br>-Хаягжуулах | Тогтмол | ГЗБТөлөвлөгөө, Усны үндэсний хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр | Төсвийн хөрөнгө Бусад талуудын хөрөнгө | Бүх худаг эзэнтэй болж ашиглалт, хамгаалалт сайжирах<br><br>Уст цэгийн мэдээллийн сан бүрдэнэ. | ЗДТГ, малчид, мэргэжлийн байгууллага |
| Усны эх үүсвэрийн хомсдол: **/усны түвшин доошлох, булаг, худгийн орчинд уул уурхайн зориулалтаар газар ухах, алт угаах /** | -Усны нөөцийн орчимд айл өрхүүдийн тоог хязгаарлах,<br>-усжуулагдаагүй бэлчээрийг усжуулах, хайгуул хийх,<br>-энгийн уурхайн худаг шинээр гаргах, засварлах<br>-усны орчинд уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох<br>-ус ашиглагчдыг тоолууржуулах<br>-цэвэр усыг эргүүлэн ашиглах<br>-ус бохирдуулсны төлбөр тогтоох, сургалт зохион байгуулах | Тогтмол | Ерөнхий төлөвлөгөө,ГЗБТ,ОН ХС,Экологийн боловсрол олгох хөтөлбөр,Засаг даргын мөрийн хөтөлбөр | Төсвийн хөрөнгө Бусад талуудын хөрөнгө | Нэмэгдсэн худаг, орсон төлбөр, лицензийн байршил | ИТХ, Засаг дарга, ЗДТГ Лиценз эзэмшигч ААН |
| | -Үүлэнд нөлөөлж бороо | Шаарлагатай | Ойн тухай үндэний | Төсөл хөтөлбөр | Модны тоо, | ИТХ, Засаг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Усны хомсдол: : **Дэлхийн дулаарал, цөлжилт, хүргүй байдал-/Нийт нутгаар/** | оруулах, хөв байгуулах<br>-усны ай савд ногоон төгөл байгуулах<br>-Булаг, шанд задгайлж сэргээх | тохиолдолд | хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Ношоон хэрэм үндэсний хөтөлбөр, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр | төсвийн хөрөнгө | хэрэгжүүлсэн төсөл | дарга, ЗДТГ, Иргэд, ТББ |
| усны хамгаалалт сулрах: **Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын өөрчлөлт, төрийн бодлого шийдвэр** | Холбогдох журам, дүрэм гаргаж мөрдөх | | Эрх зүйн хөтөлбөр, байгаль орчны эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр | | Гаргасан дүрэм, журам | ИТХ, Засаг дарга, |

### 5.3. Биологийн олон янз байдал түүний амьдрах орчны хамгааллын менежментийн төлөвлөгөө

| Сөрөг нөлөөллүүд | Зайлсхийх, бууруулах, арилгах төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа | Байгаль хамгаалах бусад төлөвлөгөө | Нийт зардал, эх үүсвэр /сая ₮/ | Шалгуур үзүүлэлт | Хариуцах тал |
|---|---|---|---|---|---|---|
| Ургамлын тоо, төрөл зүйл цөөрөх<br>- **Хур хунадасгүй байдал /ган, зуд/**<br>- **Элсний нүүдэл**<br>- **Хүний хүчин зүйл** | Сумын ургамал, амьтаны судалгааг хийж мэдээллийн сан бүрдүүлэх | 2017 онд | ЗГ-ын Ногоон хөгжлийн үөл ажиллагааны төлөвлөгөө | 1,0 | Мэдээллийн сан бүрдсэн эсэх | ЗДТГ, |
| | Бэлчээрийг хуваарьтай ашиглах, Бэлчээрийн ургамал тариалах, бэлчээр хаших | Тухайн жилд | Бэлчээрийн менежементийн төлөвлөгөө | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Бэлчээрийн менежементийн төлөвлөгөө гаргасан байдал | Малчид, төсөл хөтөлбөр |
| | Заган ойн нөхөн төлжүүлэлт хийх | Төлөвлөгөө хэрэгжих хугацаанд | Ойн үндэсний хөтөлбөр | Төсөл хөтөлбөр | Гаргасан төсөв, ургалтын хувь | Орон нутгийн удирдлага, |
| | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Тухайн жилд | ЗГ-ын Ногоон хөгжлийн үөл ажиллагааны төлөвлөгөө | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Зарцуулсан төсөв ургалтын хувь | Орон нутгийн удирдлага, |
| | Ховордсон эмийн ургамлын судалгаа, зураглал гаргах, боломжтойг нь | 2017 онд | Ойн унэдсний хөтөлбөр | Төсөл хөтөлбөр | Зарцуулсан төсөв ургалтын хувь | Орон нутгийн удирдлага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тарималжуулах | | | | | |
| | Эвдэгдсэн газруудад биологийн нөхөн сэргээлт хийх | 2016-2017 онд | Ногоон байгууламжийн төлөвлөгөөг харах | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Зарцуулсан төсөв БНС ургалтын хувь | ИТХ, Засаг дарга, |
| | Иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх /сургалт хийх/ | Жүл бүр | “Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр” | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Зарцуулсн төсөв, сургалт нөлөөллийн ажлын тоо, үр дүн | ОН-ийн удирдлага, ОТЗөвлөл |
| | Эко клубуудыг байгуулах | Жилдээ | | | | |
| | Энэ чиглэлээр суралцаж байгаа хүмүүсээр судалгаа хийлгэх | 2017-2018 онд | | | | |
| Ан, амьтны тоо толгой цөөрөх<br>- Байгалийн давагдашгүй хүчин зүйл<br>- Хүний хүчин зүйл | Ан амьтны байршлыг тогтоож, судалгаа гаргах | 2017 | “Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Судалгаа гаргасан эсэх | ОН-ийн удирдлага, Мэргэжлийн байгууллага, иргэдийн бүлэг, нөхөрлөл |
| | Ан амьтад хамгаалах иргэдийн бүлэг, нөхөрлөл байгуулах | 2017 | Ан, агнуурын менежментийн төлөвлөгөө | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Иргэдийн бүлгийн тоо | |
| | Зэрлэг амьтдад зориулсан өвс, хужир шүү, усжуулалт хийх | Тогтмол | “Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Зарцуулсан төсөв ажлын тоо | |
| | Уул уурхайн болон аялал жуулчлалын зарим маршрутыг баталж, мөрдөх | 2017 | Ашигт малтмалыг хохирол багатай олборлох хөтөлбөр | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Техникийн болон биологийн НС хийсэн талбай | |
| | Ан амьтдын менежментийг сайжруулах | 2018 | Ан, агнуурын менежментийн төлөвлөгөө | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Төлөвлөгөө гаргасан эсэх | |
| | Боломжтой амьтдыг авчирч нутагшуулах | 2019 | “Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр | Төсөл хөтөлбөр төсвийн хөрөнгө | Нутагшуулах амьмдын тоо, судалгаа | |

### 5.4. Түүхийн дурсгал, соёлын өвийн хамгааллын менежментийн төлөвлөгөө

| Сөрөг нөлөөлөллүүд | Зайлсхийх, бууруулах, арилгах төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Байгаль хамгаалах бусад төлөвлөгөө, бодлоготой уялдсан байдал | Нийт зардал, эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Хариуцах тал |
|---|---|---|---|---|---|---|
| Цаг уур /ган, зуд, хяналт сулрах/ сэрэмжлүүлэг тараах | Хяналтыг сайжруулж, ховор үнэт түүх соёлын дурсгалыг тусгайлан хамгаалах | 2016-2021 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр | 5,0 | ховор үнэт түүх соёлын дурсгал бүгд хамгаалагдсан байна. | БОБ,БХ |
| Түүх соёлын дурсгалыг зөөж тээвэрлэх, хулгайлах, эвдэж сүйтгэх | ТХГН-т болон соёлын өв бүхий газруудад хэрэгжиж буй хууль тогтоомжуудыг иргэдэд сурталчлан таниулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх | 2016-2021 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр | 15,0 | | |
| Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын соёлын өвийн бүртгэл хангалтгүй | • Бүртгэгдээгүй соёлын өвийг илрүүлж бүртгэх<br>• Дэл уулын соёлын дурсгалыг **ЮНЕСКО**-гийн соёлын өвд бүртгүүлэх | 2016-2021 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр | 10,0 | Тэмдэг тэмдэглэгээг сайжруулах | БОБ, Орон нутаг |
| ЗГ-ын үйл ажиллагаа орон нутагт уялдаагүй | Бодлого хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд боловсрулж хэрэгжүүлэх | 2016-2021 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хтөлбөр | 5,0 | | ОН-ийн удирдлаг |
| н нутгийн тусгай хамгаалалтад авах | Тусгай хамгаалалтын ангилал, зэрэглэлийг нэмэгдүүлэх Соёлын өв бүхий газар нутгийн тусгай хамгаалалтын зэрэглэлийг ахиулах | 2016-2021 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр | 0,0 | Тусгай хамгаалалттай бүс нутаг болсон байх | БОАЖГ ЗДТГ |
| Амралт аялал жуулчлалын газар байгуулах | Түүх соёлын өвийн дурсгалт газруудыг түшиглэн жуулчний газар байгуулж аялал жуулчлалыг хөгжүүлэх | 2016-2021 | Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр | 30,0 | Орон нутгийн судлах музей байгуулсан байна. | Иргэн ААН ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| умын үзсэлгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газар, экологийн чухал ач холбогдолтой газрын талаарх иргэдийн мэддэг хангалтгүй | • Сумын музей, үзэсгэлэнт газруудаар аялуулах талаар ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт оруулах<br>• Орон нутаг судлах музей байгуулах | 2017 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр | Төсөл хөтөлбөрийн санхүүжилт | мэдлэгийн сургалт хөтөлбөр нэмэгдүүлнэ | Засаг дарга, ажлын хэсэг |
| Сумын үзэсгэлэнт газрууд аялал жуулчлалын албан ёсны маршрутанд гүйцэд ороогүй | Аялалын маршрутанд оруулах<br>Үзэсгэлэнт газар, түүх соёлын танилцуулга бэлтгэх<br>Сувилал, аялал жуулчлалын газрын тоог нэмэх<br>Түүх соёлын газрыг тэмдэгжүүлэх | 2019 | ТХГН тухай хөтөлбөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр | 0.5 сая | Аялал жуулчлал хөгжих боломж бүрдэнэ | Засаг дарга, БОХУБ, ажлын хэсэг |

### 5.5. Бусад байгалийн нөөцийн болон хамгааллын менежментийн төлөвлөгөө

| Сөрөг нөлөөлөллүүд | Зайлсхийх, бууруулах, арилгах төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Байгаль хамгаалах бусад төлөвлөгөө, бодлоготой уялдсан байдал | Нийт зардал, эх үүсвэрсая | Шалгуур үзүүлэлт | Хариуцах тал |
|---|---|---|---|---|---|---|
| **5.5.1 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө** | | | | | | |
| Сумдын төв болон хөдөө нутаг дэвсгэрт буй хог хаягдлыг бууруулж, байгаль орчинд хал багатай зайлуулах | Ландфилийн аргаар дарж булшлах | 2016-2021 он | Ногоон хөгжлийн бодлого Стратег зорилт 6,4,6 | 20-30 | Байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх | ЗДТГ, малчид, иргэд, БЗДарга нар |
| Иргэдийн ухамсар муу, хог хаягдлын төлбөрөө цаг тухайд нь төлдөггүй | Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | Жил бүр | Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр | 0.1 | Иргэдийн ухамсар дээшилж, хог хаягдлын төлбөрийн орлого төвлөрнө | ЗДТГ, БЗД нар иргэд |
| Зориулалтын бус газар хог хаях, гудамж талбайд бохир усаа асгах | Камержуулах, Хөршийн хяналт, мэдээллийг худалдаж авах | Жил бүр | Хог хаягдлын хөтөлбөр | 5 | Эрүүл орчин бий болно | ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хог хаягдлын нэгдсэн цэгийг тохижуулаагүйгээс орчны бохирдол бий болсон | Шуух төмөр хашаагаар хашиx, буюу шороогоор далан бий болгох салхи, шороонд хийсэхгүйгээр хүнхээл нүхтэй байхаар хийгдэх | 2016-2017 он | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 20 | Хог хаягдал гадагш хийсэхгүй болно | ИТХ, ЗДТГ, БЗД нар иргэд |
| Нийтийн байр, орон сууц, гудамж талбай зэрэгт шаардлага хангасан хогийн сав байрлуулаагүйгээс орчны бохирдол үүсэх | Хуучин пункерийг засаж сайжруулах, шинээр пункер нэмж авах | 2016 он | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 10 | Хоггүй, цэвэр орчин бий болно | ЗДТГ, байгууллагууд |
| Төвлөрсөн хогийн цэг дээр ажилладаг зөөвөрлөдөг машин техникийг сайжруулж тогтмол цалинжуулж 1-2 хүнийг ажлын байртай болгох | Сар болгон айл өрхөөр тогтмол явж ачиж буулгах /Төвлөрсөн хогийн цэг эмхтэй болно / | Жил бүр | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 12 | Хогийн асуудал цэгцэрнэ | ЗДТГ, БЗДарга, Тээвэрлэх байгууллага |
| Хог хаядлыг булшлах, цэвэрлэхэд ашиглах техник байхгүй | Ковш маркийн авто ачигч авах | 2017-2018 он | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 80 | Хоггүй, цэвэр орчин бий болно | ЗДТГ |
| Зориулалтын бус газар хог хаях, гудамжинд бохир усаа асгах | Камержуулах, Хөршийн хяналт, мэдээллийг худалдаж авах | Жил бүр | “Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр” | 5 | Эрүүл орчин бий болно | ЗДТГ |
| Хог зөөврийн машин хуучирсан, автомашины граж байхгүй | Хог зөөврийн машиныг сайжруулах, авто гражийн асуудлыг шийдвэрлэнэ | 2016-2018 | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 30 | Хог зөөврийн үйлчилгээ сайжирна | ЗДТГ |
| Хэт нимгэн нийлэг уутыг түгээмэл хэрэглснээр байгаль орчныг ихээр бохирдуулдаг | Хэт нимгэн уутыг худалдаалахыг хориглосон захирамжийн хэрэгжилтийг хангана, байгальд ээлтэй эко уутны хэрэглээг нэмэгдүүлнэ | Жил бүр | “Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр” | 0.1 | Хоггүй, цэвэр орчин бий болно | ЗДТГ, БЗД нар |
| Хог хаягдлыг ангилан | Энэ чиглэлээр үйл | 2016-2017 | “Хог хаягдлыг | 20 | Хог хаягдлын хэмжээ | ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ялгадаггүй менежмент муу | ажиллагаа явуулах иргэн, ААН-ийг дэмжиж ажиллана | он | бууруулах үндэсний хөтөлбөр” | | багасна, иргэдын орлого нэмэгдэж ажлын байр бий болно | |
| Уурхайнууд ахуйн хог хаягдлаа хадгалах зориулалтын цэггүйгээс байгаль орчин бохирдууддаг | Уурхайнуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тавих хяналтыг сайжруулах | Жил бүр | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | Өөрийн төсөв | Орчны бохирдол багасна | СЗД, ЗДТГ, Уурхайнууд |
| Авто замын зурвас газарт хог хаягдал ихээр овоорсноос орчны бохирдох бий болсон | Зогсоол болгонд хогын сав байрлуулна | 2016-2018 он | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 1 | Хоггүй, цэвэр орчин бий болно | ЗДТГ, БЗД нар |
| Бичил уурхайн хог хаягдлыг Нэг цэгт байршуулах, устгах | Гэрээ хийж зориулалтын аргаар устгуулах | Жил бүр | Бичил уурхайчид | Өөрсдийн хөрөнгө | Хөрсний бохирдол буурах | ЗДТГ, Бичил уурхайчид |
| Нийтийг эзэмшлийн талбайд их цэвэрлэгээг байнга хийж тогтмолжуулж зориулалтын цэгт нь байршуулдаг байх | Зориулалтын хогийн цэг байгуулах | Сар болгон | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 10 | Гадна дотны зочид төлөөлөгчидөд таатай | ЗДТГ, БЗД нар |
| Хүүхдүүдэд хог хаягдлын талаар цогц ойлголт өгөх, ЕБС, СӨБ | Хичээлийн програмд суулгаж өгөх, ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж самбар байрлуулах | 2016-2021 он | “Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр” | 5 | Нийтийн эзэмшил гудамж талбай, цэвэрхэн байх | ЕБС,СӨБ, ЗДТГ, БЗДарга нар |
| Хөдөөний малчин айл өрхийн хогийн асуудал | Шатах, шатахгүй, гэж 2 ангилна. | Жил бүр | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 2 | 4- улиралдаа нутагласан газрын орчин цэвэрхэн байх | БЗДарга, малчид |
| Хуучин хог хаягдлын цэгүүдийг цэвэрлэж дуусаагүйгээс хур хог бий болсон | Нэгдсэн цэгрүү зөөж булшлах | 2016-2018 он | “Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” | 10 | Хоггүй, цэвэр орчин бий болно | ЗДТГ, ААН |

| Сөрөг нөлөөлөл | Зайлсхийх, бууруулах, арилгах | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Байгаль хамгаалах бусад төлөвлөгөө бодлоготой уялдсан байдал | Нийт зардал эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Хариуцах тал |
|---|---|---|---|---|---|---|
| **5.5.2 Агаарын бохирдолыг бууруулах менежементийн төлөвлөгөө** | | | | | | |
| Тоосжилт, агаарын хуурайшилт ихсэх | Уул уурхайн ХХК–уудад усалгааны систем тогтмол ашиглахыг шаардах гэрээнд хатуу заалтаар оруулах | Гэрээнд тусгаж тухай бүр мөрдөж ажиллах | Ойн тухай үндэсний хөтөлбөр | ХХК-ууд | Зөвшөөрөгдсөн талбайн орчин чийгшил авсан тоосжилгүй байх | ЗД ХХК -ууд |
| | ААН, Албан байгууллагуудын ногоон байгууламжийн хэмжээг тогтоож өгөх, ойжуулах | Жил бүр | Агаарын бохирдолыг бууруулах төлөвлөгөө | ОНХСанг ийн хөрөнгө 5сая төгрөг | Өнөөгийн байгаа 2796 мод суулгацын тоо нэмэгдсэн байх | ЗДТГ зохион байгуулна |
| | Тээвэрлэлтийн замыг нэгдсэн нэг сүлжээ, маршрутад оруулах, замын тэмдэглэгээ, анхааруулга байршуулах, зам дагасан ойжуулалт хийх | Жил бүр | Ойн тухай үндэсний хөтөлбөр | 1 сая | 2016 оны байдлаар тооцогдсон замын сүлжээ нэмэгдэхгүй байх | Засаг дарга<br><br>Бичил уурхай эрхлэгчид<br>ХХК-ууд |
| **5.5.3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, дүйцүүлэн хамгаалахыг дэмжих төлөвлөгөө** | | | | | | |
| Гандах, хөрсний чийгшил багасах<br>Хур тундасатай өдрийн тоо жилийн дунджаас багасах<br>Улмаар хүн, малын эрүүл мэндэд нөлөөлөх | Сумын төвд засмал зам бий болгох | 2016 онд | Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр | 1 тэрбум | Засмал зам тавигдсан байна | ЗД<br>ЗГ-ийн “ Дэд бүтэц” хөтөлбөрийн хүрээнд |
| | Зам дагуу мод зүлэг тарималжуулах | 2016 онд | Ногоон хэрэм хөтөлбөр | 1 тэрбум | Нийт замын уртад дүйцэх хашлага хэлбэрээр тарьсан байх | |
| | Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Жил бүр | Ногоон хэрэм хөтөлбөр | | 100га талбай хүрсэн байх | ЗД, Иргэд ИНБ-УУД |
| | Сумын төвд явган хүний тавих, байгууллага бүр | 2016-2020 | Ногоон хэрэм хөтөлбөр | 10,0 | | Төсөв шууд захирагч нар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | гадна талбайг цементлэх замаар тоосжилтыг багасгах, Ногоон байгууламж байгуулах | | Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр | | | |
| | Тээвэрлэлтийн голлох зам дагуу газруудад бэлчээр хаших хэлбэрээр хамгаалах, модлог бутлаг ургамал дэрс, дов сондуулыг хамгаалж, чийг хадгалах хэлбэрээр/ | Жил бүр | Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийг бууруулах хөтөлбөр<br>Ногоон хэрэм хөтөлбөр | 30,0 | Хашсан бэлчээрийн га талбай нэмэгдсэн байх | ЗД<br>БЗД<br>Малчид |
| | Биологийн нөхөн сэргээлт хийх<br>Олон наст ургамал тариалах | ТУХАЙ БҮР | Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийг бууруулах хөтөлбөр<br>Ногоон хэрэм хөтөлбөр | 25,0 | Гэрээнд нөхөн сэргээх талбайн га хэмжээ, ургацыг тодорхой тусгах | ЗД<br>ТББ<br>ХХК-ууд |

## Зургаа. Сумын байгаль орчны менежементийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тогтолцоо

### 6.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг, хариуцлага

Сумын байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн бүхий л суурь судалгаануудад үндэслэн энэхүү менежментийн төлөвлөгөөг боловсруулж байна. Иймд тус төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтууд, төлөвлөсөн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн бодит үр дүнд хүрэхийн тулд оролцогч талууд хууль ёсны эрх ашгийнхаа хүрээнд хамтын оролцоог тогтмол хангаж, үүрэг хариуцлагаа ухамсарлаж ажиллах шаардлагатай юм. Оролцогч талуудад дараах хөгжлийн оролцогчид хамрагдана.

- Сумын ИТХ
- Сумын ЗДТГ
- Албан байгууллагууд
- Малчид, иргэдийн бүлэг
- Сумын Олон талт зөвлөл /ОТЗ/
- БУЭ-дийн нөхөрлөл, ТББ
- Лиценз бүхий уул уурхайн компани

### 6.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг чадавхижуулах

Оролцогч талуудыг чадавхижуулах үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|
| 1 | ОТЗ-ийн гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах, хамруулах | 2016-2017 онд | ИТХ, ЗД | Зөвлөлийн гишүүдийн ажиллах чадвар сайжирна. |
| 2 | Багуудын ИНХ-д малчид, иргэдэд байгаль орчны талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаануудыг тогтмол хийх | Жил бүр | ЗД,<br>ОТЗ-ийн гишүүд | Малчид, иргэд байгаль орчны талын мэдлэг, мэдээллээр хангагдана. |
| 3 | ОТЗ-ийн гишүүдийг туршлага судлуулах | 2017 онд | ИТХ, ЗДТГ | Зөвлөлийн үйл ажиллагаа сайжирна. |
| 4 | ЕБС-ийн сурагчдын дунд байгуулагдсан эко бүлгийг чадавхижуулах, “**Эко танхим**” байгуулах | 2017 онд | ЕБС, ОТЗ | Хүүхэд, залуучуудын экологийн боловсрол нэмэгдэнэ. |
| 5 | ОҮИТБ-ын олон талт хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн жил бүр зохион байгуулах | Жил бүрийн 1-р улиралд | ИТХ | Талуудын хамтын ажиллагаа, чадавхи сайжирна. |

### 6.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээ ба тайлагнал

Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч гол талууд нь сумын ЗДТГ, төрийн байгууллагууд, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх салбарын аж ахуйн нэгж, компани, байгууллагууд байна.

- Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс байгуулсан төлөвлөгөөний хэрэгжилт, явцад хяналт тавих ажлын хэсэг болон сумын Олон талт зөвлөл хамтран төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, багийн ИНХ, сумын ИТХ-д тус бүр жилд 1 удаа тайлагнаж үр дүнг тооцож ажиллана.
- Сумын ИТХ-аас тайланг хэлэлцэн шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөний зорилго, зорилтын дагуу зохицуулалт хийж, шийдвэр гаргаж болно.
- Төлөвлөгөөг үнэлэхдээ голлон тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжинэ.
- Зарим арга хэмжээнүүдийн /ихэвчлэн уул уурхайн төслүүд/ биелэлтийг малчид, иргэд, мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж тооцно.
- Чиглэл тус бүрийн асуудлыг холбогдох яам, агентлаг, газартай нь харилцаа тогтоож, хамтран ажиллаж шийдвэрлэх арга замыг хайна.

### 6.4. Санхүүжилтийн тогтвортой, баталгаатай эх үүсвэр

- Өнөөгийн сумын хэмжээнд байгалийн нөөц баялаг ашиглагч иргэн, ААН, байгууллагаас орох орлогын хэмжээг ААН, байгууллага болон орлогын эх үүсвэр бүрээр харуулж тооцно.
- Сумын ИТХ-аар байгалийн нөөц баялгийн ашиглалтын орлогын хэмжээг орон нутагт тогтоосон тогтоол гаргаж мөрдүүлнэ.
- Орон нутгийн төсвөөс байгаль орчинд зарцуулах хөрөнгийн сүүлийн 3 жилийн дундаж хэмжээг тооцож гаргана.
- Төсөл хөтөлбөрүүдтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийн зардал.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ

### Долоо. Эрсдлийн менежментийн төлөвлөгөө

### 7.1.Санхүүгийн тогтворгүй байдлаас үүсэх эрсдэл

- Санхүүжилт хангалттай биш байх
- Тогтвортой эх үүсвэр төлөвлөхгүй байх
- Санхүүжилтийг үр дүнгүй зарцуулах

*Эрсдлийг бууруулах хариу арга хэмжээ:*

- *Жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлд зохих төсвийг суутгаж байх*
- *ОНХС-ийн хөрөнгө, Олон улсын төсөл, хөтөлбөр, хандив тусламжид хамрагдах*
- *Уул уурхайн компанитай хамтран ажиллах гэрээнд заалт болгож оруулдаг байх*
- *Иргэн бүрийн оролцоог хангаж Сайн дурын хөдөлгөөнүүдийг өрнүүлэх*

### 7.2. Байгаль цаг агаарын давагдашгүй хүчин зүйлээс үүсэх эрсдэл

- Ган, зуд, бүс нутгийг хамарсан онц аюулт өвчин гарах

*Эрсдлийг бууруулах хариу арга хэмжээ:*

- *Албан тушаалтнууд, малчид, иргэдийг онцгой байдалд ажиллах анхан шатны сургалтад хамруулах*
- *Үүлэнд нөлөөлж хур тунадас оруулах*
-

## 7.3. Удирдлага зохион байгуулалт, талуудын оролцооны чанараас хамаарах эрсдэл

- ОТЗ-ийн үйл ажиллагаа жигд биш байх
- Сумын ИТХ болон ЗД-ын идэвх санаачлага сулрах
- Иргэдийн оролцоог өрнүүлэх, ААН, байгууллагын үүргийг орхигдуулах
- Талуудыг чадавхжуулах, оролцоог тэгш хангах талаар тогтвортой үйл ажиллагаа явуулахгүй байх
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тогтсон хугацаанд үнэлж, сайжруулах талаар ажил хийгдэхгүй байх

*Эрсдлийг бууруулах хариу арга зам:*

- *БОМТ-ний дагуу жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж байх*
- *ОТЗ –ийн хурлаар хагас жил тутамд БОУБ-гч танилцуулга хийдэг байх, мөн талуудын үйл ажиллагааны танилцуулга сонсдог, тайланг нээлттэй болгох*
- *Жилийн эцсийн ИТХ –ын хуралдаанаар СБОМТ-ний хэрэгжилтийг дүгнэж хэлэлцдэг байх.*
- *БОМТ-г хэрэгжүүлэх ажлыг ИТХ дахь байгаль орчин, ХАА-н ажлын хороо хариуцан хяналт тавьж ажиллах*

## 7.4. Улс төрийн тогтворгүй байдал, төрийн залгамж чанар алдагдахаас үүсэх эрсдэл

- Улс төр, намчирхах ашиг сонирхлоор БОМТ-ний баримт бичгийг хэрэглэхгүй байх
- Улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчид тогтворгүй байх

*Эрсдлийг бууруулах хариу арга зам:*

- *БОМТ-ний баримт бичгийг сумын урт хугацааны бодлогын баримт гэж үзэж хүлээн зөвшөөрөх*
- *Сонгуульд оролцогч улс төрийн хүчнүүд энэхүү баримт бичгийн агуулгыг мөрийн хөтөлбөртөө тусгаж хэрэгжүүлэх*
- *Төлөвлөгөөг сумын нийт айл өрх, иргэдэд таниулан түгээж сурталчлах*

## ХАВСРАЛТ

### Уул уурхайн лицензийн жагсаалт

Өлзийт сумын нутаг дэвсгэрт 2016 оны 5-р сарын 10-ны байдлаар ашигт малтмалын хайгуулын 27, ашиглалтын 4 тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэлтэй байгаагийн 22 нь дан сумын нутагт, 9 нь хил залгаа орших Хулд, Луус, Сайнцагаан, Гурвансайхан, Өмнөговь аймгийн Манлай зэрэг сумдтай хил дамнан оршиж байна. Жагсаалтыг дор харуулав.

| № | ТЗ-ийн дугаар | Талбайн нэр | Талбайн хэмжээ (га) | Аймаг | Сум / дүүрэг | Эзэмшигч | Ашигт малтмал | Олгосон огноо | Дуусах огноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1017 | Хайрхан | 31 721,13 | Дундговь | Өлзийт | Гурвансайхан |  | 1998.02.24 | 2016.01.02 |
| 2 | 6399 | Хөтөл ус-2 | 43,06 | Дундговь | Өлзийт | Адил-Оч | Жонш | 2003.10.04 | 2033.10.04 |
| 3 | 13938 | Шивээгийн гозгор | 1 864,73 | Дундговь | Өлзийт | Си Эм Си Эм |  | 2008.07.28 | 2017.07.28 |
| 4 | 15422 | Өлзийт | 5 223,72 | Дундговь | Өлзийт | Стамина |  | 2010.01.20 | 2019.01.20 |
| 5 | 14911 | Үнст худаг | 1 637,63 | Дундговь | Гурвансайхан, Өлзийт | Билэгтхайрхан уул | Нүүрс | 2009.05.18 | 2039.05.18 |
| 6 | 14126 | Бор толгой | 9 245,88 | Дундговь | Өлзийт | Шинэлонгда |  | 2008.09.09 | 2017.09.09 |
| 7 | 12239 | Цант уул-1 | 87,45 | Дундговь | Өлзийт | Мөнхийн жонш | Жонш | 2006.11.22 | 2026.11.22 |
| 8 | 17487 | Илрэл | 1 317,92 | Дундговь | Өлзийт | Тогтохмандал |  | 2010.02.12 | 2019.02.12 |
| 9 | 17648 | Бага хөх цав | 4 454,54 | Дундговь | Өлзийт | Хаадын эрдэнэс |  | 2015.01.08 | 2018.01.08 |
| 10 | 15579 | Цагаан толгой | 14 368,95 | Дундговь, Өмнөговь | Өлзийт, Манлай | Дэвжих арвин орд |  | 2010.04.16 | 2019.04.16 |
| 11 | 17303 | Хөх дэл | 4 720,16 | Дундговь | Өлзийт | Алкалли метал монголиа | Литий | 2013.04.18 | 2043.04.18 |
| 12 | 12685 | Хөх дэл | 12 410,94 | Дундговь | Өлзийт | Алкалли метал монголиа |  | 2007.09.06 | 2018.09.06 |
| 13 | 17024 | Шивээгийн гозгор | 240,95 | Дундговь | Өлзийт | Си Жи Си Эм |  | 2008.07.28 | 2017.07.28 |
| 14 | 19559 | Баяншираэ | 5 778,83 | Дундговь | Өлзийт, Хулд | Эко энвайронментал консалтинг |  | 2016.03.28 | 2019.03.28 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 19579 | Тал | 3 630,32 | Дундговь | Луус, Өлзийт | Хэрлэн-Энерго | | 2015.12.22 | 2018.12.22 |
| 16 | 19018 | Өлзийт-1 | 505,45 | Дундговь | Өлзийт | Мэжикбридж | Жонш | 2015.07.27 | 2045.07.27 |
| 17 | 19115 | Харгант уул | 4 802,52 | Дундговь | Өлзийт | Фэйстмедиа групп | | 2016.01.27 | 2019.01.27 |
| 18 | 19644 | Хулд | 575,56 | Дундговь | Өлзийт, Хулд | Голден санрайз энержи | | 2015.12.11 | 2018.12.11 |
| 19 | 20378 | Цагаан дэл | 215,68 | Дундговь | Өлзийт | Эрдэсплазм | | 2016.02.08 | 2019.02.08 |
| 20 | 20097 | Хар тойром | 27 349,74 | Дундговь | Гурвансайхан, Өлзийт | Билэгтхайрхан уул | Нүүрс | 2015.11.18 | 2045.11.18 |
| 21 | 20098 | Хар тойром | 23 062,99 | Дундговь | Гурвансайхан, Өлзийт | Билэгтхайрхан уул | Нүүрс | 2015.11.18 | 2045.11.18 |
| 22 | 19525 | Цагаан | 230,89 | Дундговь | Өлзийт | АШМАГ | | 2015.12.22 | 2018.12.22 |
| 23 | 19983 | Улаан толгой | 1 573,92 | Дундговь | Өлзийт | Стар металс | | 2016.01.13 | 2019.01.13 |
| 24 | 19341 | Цагаан дэрс | 1 359,86 | Дундговь | Өлзийт, Хулд | Эх орд майнинг | | 2015.11.23 | 2018.11.23 |
| 25 | 20145 | Баян чулуут | 9 058,25 | Дундговь | Өлзийт | Түрүү инфо эйжэнси | | 2016.02.03 | 2019.02.03 |
| 26 | 20162 | Шанд | 9 320,73 | Дундговь | Өлзийт | Оюу ресурс | | 2016.02.04 | 2019.02.04 |
| 27 | 19735 | Оорцог | 22 081,00 | Дундговь | Өлзийт | Их монгол коммерс | | 2016.04.27 | 2019.04.27 |
| 28 | 19739 | Өлзийт | 63,22 | Дундговь | Өлзийт, Хулд | Терра виста | | 2016.01.11 | 2019.01.11 |
| 29 | 19857 | Цагаан толгой | 10 419,43 | Дундговь | Өлзийт | Голден хаммер | | 2016.01.07 | 2019.01.07 |
| 30 | 19887 | Цагаан дэл | 4 119,84 | Дундговь | Өлзийт | Өгөөмөргөвийн нуур | | 2015.12.22 | 2018.12.22 |
| 31 | 19427 | Орд | 24 596,82 | Дундговь | Луус, Өлзийт, Сайнцагаан | Цахирт өндөр майнинг | | 2015.12.02 | 2018.12.02 |

## Өлзийт сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлын хэсэг

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 04 сарын 28 өдөр Дугаар 16 Рашаант

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Сумын ИТХ-ын дарга

Гишүүд: Сумын Засаг дарга
ИТХ-ын нарийн бичгийн дарга
Засаг даргын орлогч
БО-ны байцаагч-газрын даамал
ЗДТГ-ын дарга
МЭҮТ-ийн дарга
Багийн Засаг дарга нар
Ахмадын хорооны дарга
Залуучуудын холбооны дарга
Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
Эрэгтэйчүүдийн холбооны дарга
“Өлзийт хишиг буян” ТББ-ын төлөөлөл
Н.Цэвэгмэд /иргэний төлөөлөл/
Н.Гомборагчаа /Байгаль хамгаалагч/
Б.Бадрах /Байгаль хамгаалагч/
О.Буяндэлгэр/цаг уурын ажиглагч/

Хоёр. Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орсон асуудлыг сумын стратеги төлөвлөгөө, Засаг даргын мөрийн хөтөлбөр,ОНХС-ын жагсаалт,бусад төсөл,хөтөлбөрт тусгуулан хэрэгжүүлэх, сурталчилах, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч/Х.Отгонмөнх/-д даалгасугай.

ДАРГА Х.ОТГОНМӨНХ

**Төлөвлөгөө боловсруулахад ашигласан материал**


1. "Өлзийтийн хөгжил" нийгэм, эдийн засгийн 2009-2020 оны хөгжлийн төлөвлөгөө
2. Дундговь аймгийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөө 2012-2030 он
3. Монгол улсын ногоон хөгжлийн бодлого
4. Сумын засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
5. Дундговь аймгийн Өлзийт сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө 2004 он
6. "Өлзий буян дэлгэрсэн Өлзийт нутаг мину" 90 жилийн ойн ном 2014 он
7. Монгол орны өмнийн говийн бүс нутагт "хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь" БОНХЯ 2014 он
8. Монгол орны биологийн олон янз байдал ба бичил уурхай. Азийн сан 2015 он
9. Дундговь аймгийн ус цаг уурын хүрээлэнгийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны судалгаа. 2016 он
10. Өлзийт сумын 2015 оны газрын нэгдмэл сангийн тайлан

**Төлөвлөгөө боловсруулахад оролцсон, санал өгсөн хүмүүс**

Х.Отгонмөнх /ИТХ-ын дарга/

И.Эрдэнэбилэг /сумын Засаг дарга/

А.Эрдэнэбат /Засаг даргын орлогч/

Э.Одгэрэл /Байгаль орчны байцаагч, газрын даамал/

Ж.Наранжав /ИТХ-ын нарийн бичгийн дарга/

Б.Хорлоо /ЗДТГ-ын дарга/

Н.Цэвэгмэд /ИТХын Тэргүүлэгч, иргэний төлөөлөл/

Ө.Буд-Очир /6-р багийн Засаг дарга/

П.Алтанцэцэг /2-р багийн Засаг дарга /

Д.Наваантаяа /3-р багийн Засаг дарга /

Ч.Эрхэм /4-р багийн Засаг дарга /

О.Ган /5-р багийн Засаг дарга /

Л.Самдан /МЭҮТ-ын дарга/

О.Буяндэлгэр /цаг уурын ажиглагч/

Н.Гомборагчаа /Байгаль хамгаалагч/

Б.Бадрах /Байгаль хамгаалагч/

Ж.Шар /Ахмадын хорооны төлөөлөл/

Ц.Наранбаатар /Залуучуудын холбооны төлөөлөл/

Ц.Бат-Очир /"Өлзийт хишиг буян" ТББ-ын төлөөлөл/

Ч.Оюунбаатар /Эрэгтэйчүүдийн холбооны төлөөлөл/